

УЛС ТӨР

Эрчим хүчний компаниудад бүтцийн өөрчлөлт хийнэ

→ 2

ЭДИЙН ЗАСАГ

Монголын компаниудын маркетинг олон улсын түвшнээс 50 хувийн хоцрогдолтой байна

→ 9

ЗУРХАЙ

XVII жарны "Хотол төгс" хэмээх төмөр хулгана жилийн үр

→ 14

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

→ 20-21

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ



2020.02.21, БААСАН~№036 (1315)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1,613.00 0.59%	5,773.00 0.67%	600.00 7.69%	52.08 16.34%	102.56	108.18	102.38	103.39	2758.95	394.36	43.33	2.32

Covid-19-ийн халдвар Солонгосоос орж ирэх аюул нүүрлэлээ



Тус улсад 47000 монгол ажиллаж амьдарч байна. Зөвхөн өнгөрсөн сард гэхэд БНСУ руу манайхаас 34000 хүн зорчжээ.

→ 7

Б.Гантиг, ЗГМ сонин

БНСУ-д COVID-19 халдварын тархалт огцом нэмэгдлээ. Хоёрдугаар сарын 19-ний өдрийн байдлаар БНСУ-д коронавирусийн

халдварын тохиолдол нийт 82 болж, өчигдөр нэг хүн нас барлаа. Үүнээс сүүлийн 13 тохиолдол нь Умард Гёнсан мужийн Дэгү хотоос илэрсэн бөгөөд вирусийн халдвар ахуйн замаар хурдацтай тархаж болзошгүй байгааг тус улсын

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Өвчинд хяналт тавих, урьдчилан сэргийлэх төвөөс анхааруулсаар байна. Халдварын тохиолдлууд БНСУ-ын Сөүл, Инчон, Гуанжу, Кёнги, Гуян, Пёнтек, Бүчон, Сувон, Гүри болон умард Чолла

мужийн Гүгсан, өмнөд Чолла мужийн Нажу, умард Гёнсан мужийн Дэгү хот болон Инчон олон улсын нисэх буудлаас илэрчээ. Зөвхөн нэг өдрийн дотор гэхэд шинээр 31 тохиолдол бүртгэгдсэн байна.

→ 4

Хорьсон ч тэмдэглэнэ, хориогүй ч тэмдэглэнэ

→ 6

Айл хэсэхдээ маск зүүж, гараа сайн ариутгавал гайгүй байлгүй дээ. Тэгээд ч коронавирус Монголд орж ирсэн нь батлагдаагүй байхад ингэж сүржигнэх хэрэг байгаа юм уу" хэмээн ярих нэгэн ч байна.

Төмөр зам барих эсвэл төсвийн алдагдлаа нөхөх сонголт байна

→ 8

"Эрдэнэс Тавантолгой"-н нийт хувьцааны 85 хувийг төр эзэмшдэг.

Хаяад явсан эцгийгээ хуримдаа урих гэж үү

→ 13

Адал явдалд дурлагч М.Бумаа

→ 17



Өнөөдөр	Маргааш
-11°C ☁	-6°C ☁
-19°C 🌙	-20°C 🌙



НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Караокед арзганаж, бааранд бужигнаж байгаа цагт коронавирус тархах аюул хэвээр

→ 5



#543 \$4.4 тэрбум

Иван Галсенберг, Glencore-ийн захирал, Швейцарын тэрбумтан

Компани хувьцаа эзэмшигчдэдээ ашигтай байхаас гадна тухайн улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулдаг байх ёстой.



УЛС ТӨР

ЗАСГИЙН ГАЗАР

Эрчим хүчний компаниудад
бүтцийн өөрчлөлт хийнэ

2019 онд ойролцоогоор 11 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан

Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

Б.Сэлэнгэ, ЗГМ сонин

Сонгуулийн циклээр буюу дөрөв дөрвөн жилээр эрчим хүчний салбарын инженер, техникийн ажилчид болон удирдах албаны хүмүүсийг сольсон нь системийн хэмжээнд хөгжил удаашрах, бодлого буруу явах үндсэн шалтгаан болсон гэж Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн хэллээ. Тиймээс цаашид энэ байдлыг гаргуулахгүйн тулд хүний нөөцийн дэд бүтцээ сайн хөгжүүлж, эрчим хүчний салбарын дунд хугацааны хөтөлбөрийг баталсан гэв. Эрчим хүчний салбар өнгөрсөн онд хийсэн ажил, энэ жилийн төлөвлөгөөгөө танилцуулсны дараа зарим зүйлийг тодрууллаа.

-Та эрчим хүчний салбарын хүний нөөцөд бодлогын шинэчлэл хийх талаараа ярилаа. Одоо энэ салбарын хүний нөөцийн чадавх ямар байгаа вэ?

-Тооны хувьд хэтэрхий данхайсан байна. 100-200 хүн ажиллах станц дээр мянгаараа ажиллаж байна. Үүнийг л өөрчилж гэж байгаа юм. Гэхдээ өөрчлөхийн тулд станцыг автоматжуулж, өндөр технологи оруулж ирэх ёстой. Өндөр технологи оруулж ирэхийн тулд хүн нь бэлэн байх ёстой. Тиймээс хүний нөөцөө чадавхжуулах, сургахад энэ жил анхаарч ажиллана. Сургасан хүмүүс маань Монголдоо буцаж ирэхгүй байх үзэгдэл их байна. Тиймээс энэ хүмүүстээ салбартаа ажиллах боломжийг олгоё гэж байгаа юм.

-Мэргэжлийн бус хүн эрчим хүчний салбарт хэр олон байгаа вэ?

-Удирдлагын түвшинд

байсныг нь бид өөрчилсөн. Мэдээж инженерийн ажлын байран дээр эдийн засагч томилчихсон байгаагүй. Гэхдээ шаардлагагүй орон тоонуудыг бий болгосон байгаа юм. Тэгж байж шахааны хүмүүсээ оруулсан зүйл бий. Тиймээс бид компаниуд дээр үе шаттай бүтцийн өөрчлөлт хийнэ.

-Импортын эрчим хүчийг бууруулахын тулд ямар ажил хийх вэ?

-Монгол Улс эрчим хүчний нийт хэрэгцээний 19 хувийг импортоор авч байна. Гол хэрэглээ "Оюутолгой" дээр байна. Жил гаруйн өмнө яг энэ өрөөнд станц барих тухай гэрээг "Оюутолгой"-той байгуулсан. Гэвч хөрөнгө оруулагч тал элдэв шалтаг тооцоод ажил хийхгүй байна.

**ШААРДЛАГАГҮЙ
ОРОН
ТООНУУДЫГ
БИЙ БОЛГОСОН
БАЙГАА ЮМ.
ТЭГЖ БАЙЖ
ШАХААНЫ
ХҮМҮҮСЭЭ
ОРУУЛСАН ЗҮЙЛ
БИЙ.**

-"Оюутолгой"-н цахилгаан станцын ТЭЗҮ батлагдсан юм биш үү?

-ТЭЗҮ батлаагүй. Зөвхөн саналууд ирсэн. Тухайлбал, сэргээгдэх эрчим хүчээр хангаа гэдэг ч юм уу хүлээж авахааргүй саналууд хэлж байна.

-Эрчим хүчний салбар алдагдалтай ажиллаж байгаа. Энэ алдагдлаа хэрхэн бууруулах вэ?

-2019 онд ойролцоогоор 11

тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Өөрөөр хэлбэл бид гаргасан зардлаа орлогоороо нөхөж чадахгүй байна. Тиймээс хөрөнгө оруулалт, техникийн шинэчлэлээ хийж чадахгүй байна. Инфляцын өсөлттэй уялдуулан эрчим хүчний үнийг нэмж, техникийн шинэчлэлээ хийе гэхээр бүгд эсэргүүцнэ. Өнгөрсөн жил эрчим хүчний үнэ нэмэгдсэн. Энэ нь дэмжих тариф буюу нар, салхины станцтай холбоотой. 90 мегабайтын нар, салхины станцыг дэмжих тариф орсон учраас эрчим хүчний үнийг нэмсэн. Үүн дээр л асуудал үүссэн. Ам.долларын ханш 1240 байсан бол өнөөдөр 2700 төгрөг давчихаад байна. Тэр хэмжээгээр бид алдагдал хүлээж байгаа. Бид гаднаас тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, түлш авч байна. Гэхдээ тарифын үнээ өсгөөгүй учраас систем алдагдалтай ажиллаж байна.

-Хэрэглэгчид, цахилгаан халаагуур хэрэглэж байгаа айл өрхүүд эрчим хүчний үнийн өсөлтийн дарамтыг хамгийн их мэдэрч байна?

-Энэ асуултыг Эрчим хүчний зохицуулах хороонд тавих ёстой. Үнэ тарифын асуудал бодлогод байхгүй. Мэдээж хамгийн үр ашигтай байх бүтцээр ажиллаж гэж ярьж буй. Харин таны тавьж буй асуултыг 2002 оноос хойш хуулиараа Эрчим хүчний зохицуулах хороо шийдээд явж байна. Тэнд гурван төлөөлөл байгаа. Хэрэглэгчийн эрх ашиг, компаниуд, Засгийн газрыг төлөөлсөн талууд ярьж байгаад тарифыг шийдэж байна. Бидний хувьд гомдолтой байдаг нь хөрөнгө оруулалт хийж чадахгүйгээр алдагдал хүлээж байгаа явдал. Нэг зүйлийг хэлэхэд айл өрхийн

ЭШЛЭЛ



Монгол Улсын худалдааны гол түнш бол БНХАУ. Манай улсын экспортын 93 хувь, импортын 34 хувь Хятад улсаас хамааралтай. Шинэ халдвар гарсантай холбоотой макро эдийн засаг саарах төлөвтэй байна. Олон улсын шинжээч эдийн засагчдын тооцооллоор гурав, дөрөвдүгээр сар эдийн засгийн хүндрэлийн дээд цэг байх болно. Үүнээс цааш эдийн засаг богино хугацаанд сэргэнэ гэж тооцоолж байна. Монголбанкны валютын нөөц 4.3 тэрбум ам.долларт хүрч, сүүлийн жилүүдээс дөрөв дахин нэмэгдсэн. Харилцагч, банк хоёр зээлийн гэрээ хийдэг ч эдийн засгийн идэвх саарч байгаатай холбоотой зээлд бүтцийн өөрчлөлт хийж болдог зохицуулалт бий. Энэ тал дээр анхаарч ажиллана гэж банкны удирдлагуудтай хийсэн уулзалтын үеэр байр сууриа илэрхийлсэн.

Монголбанкны Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэн

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 02 дугаар сарын 21 ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: "Цэвэрлэгээний бараа материал" нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер
Тендер шалгаруулалтын дугаар: МИАТ/202002104

МИАТ ТӨХК нь эрх бүхий тендер оролцогчдоос "Цэвэрлэгээний бараа материал" нийлүүлэх 3 багц бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна.
Багц 1 Цэвэрлэгээний бодис, материал
Багц 2 Ариун цэврийн цаас, хогийн уут
Багц 3 Гарын шингэн саван

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул <http://www.tender.gov.mn> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 төгрөг, төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна. Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил 2018, 2019 онуудад доод тал нь санал болгож буй үнийн 100 хувиас доошгүй хэмжээний цэвэрлэгээний бараа материалын худалдах, худалдан авах гэрээ байгуулж үндсэн нийлүүлэгчээр ажилласан байх ба гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ.

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгэн жилд борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгэн 100% -аас багагүй Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн 60%-аа багагүй байна.

Тендерийн хамт
Багц 1-1,695,735.00 төгрөг
Багц 2-879,780.00 төгрөг
Багц 3-701,568.00 төгрөгийн үнийн дүнтэй тус тус тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 13.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 13.10 цагт нэнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй
Дотоодны давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа, МИАТ ТӨХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө,
www.tender.gov.mn, Утас: 70049860, Факс: 70049919

“Метрополитен” театрын тайзнаа дөрөв, тавдугаар сард “Травиата” дуурийн Жорж Жермоны дүрд дуулна.



Э.Амартүвшин гавьяат “Метрополитен”-ы тайзнаа дуулна

Б.Мөнхзул, ЗГМ сонин

Италийн Верона хотын “Арена” задгай театрын тайзнаа энэ зун дэлхийн дуурийн алдартай дуучидтай хамтран дуурьт тоглож, дуурийн “Оскар” хэмээн нэрлэдэг олон улсын дуурийн найм дахь удаагийн арга хэмжээний дуурийн шилдэг дуучны шагналд Э.Амартүвшин нэр дэвшсэн талаар бид өмнө нь мэдээлсэн. Тэгвэл түүнтэй холбоотой өөр нэгэн шинэ мэдээлэл цацагдав. Тодруулбал, Монгол Улсын гавьяат жүжигчин

Э.Амартүвшин дэлхийн хамгийн нэр хүндтэй театруудын нэг Нью-Йоркийн алдарт “Метрополитен” театрын тайзнаа ирэх дөрөв, тавдугаар сард дуулахаар болсон байна. 3900 үзэгчийн суудалтай “Метрополитен” театрын тайзнаа алдарт хөгжмийн зохиолч Ж.Вердийн “Травиата” дуурийн гол дүр эцэг Жорж Жермоныд дуулах хөтөлбөрийг түүнд ирүүлжээ. Э.Амартүвшин гавьяат өдгөө өөрийн төрсөн нутаг болох Сүхбаатар аймгийн Халзан суманд амарч байгаа бөгөөд сар шинийн дараа

хилийн дээс алхах юм байна. Тэрбээр дөрвөн жилийн өмнө хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Би “Метрополитан”, “Ла Скала” зэрэг дэлхийн том том театрын тайзнаа гарч үзэхийг, дуулахыг мөрөөддөг. Мөн баритон хоолойн том том дүрийг бүтээхийг хүсч байна. Отелло дуурийн Яго, Набуко, Макбет гээд л. Одоо бидэнд дэлхийн том театруудад, нэртэй уран бүтээлчидтэй дуулах карьераа эхлэх ажил үлдэж байгаа юм” хэмээн ярьж байсан билээ. Тэгвэл түүний мөрөөдөл биеллээ олж байна. ■

У.Насанжаргал их мастерын болзол биелүүлжээ

Шатрын их мастерын норм олгох Third Saturday цуврал тойргийн гурав дахь тэмцээн Сербийн Нови-Сад хотноо болжээ. Уг тэмцээнд олон улсын мастер У.Насанжаргал, Д.Батсүрэн нар оролцож, их мастерын нормын болзол биелүүлэхээр өрсөлдөв. Тэгвэл олон улсын мастер У.Насанжаргал дээрх тэмцээнд есөн өрөг тоглож, долоон оноо авснаар мөнгөн медаль

хүртээд зогсохгүй их мастерын сүүлчийн нормыг биелүүлжээ. Мөн тэрбээр чансаагаа 13.1-ээр ахиулсан байна. Хэнтий аймгийн Батширээт сумын харьяат тэрбээр одоо чансаагаа 2600-гаас дээш гаргах зорилготой гэнэ. Дэлхийн шатрын холбооноос батламжилсан тохиолдолд тэрбээр Монголын 11 дэх эрэгтэйчүүдээс тав дахь их мастер болж байгаа юм. ■

Г.Ялалт “Алтан баавгай”-н төлөө өрсөлдөнө

Жүжигчин Г.Ялалт Берлиний кино наадамд оролцохоор хүлгийн жолоо залжээ. Тэрбээр өөрийн цахим хуудастаа “70 дахь удаагийн Берлиний кино наадмыг зорихоор мордлоо. Олон улсын наадамд Монголоороо гоёод ирнэ ээ” гэсэн байв. Энэхүү наадамд Германы Basis Berlin кино компани болон Араб, Австри, Монгол зэрэг улсын уран бүтээлчидтэй хамтран бүтээсэн “Алтан

судал” киногоороо “Алтан баавгай” шагналын төлөө өрсөлдөх ажээ. Basis Berlin-ий уран бүтээлчид 2018 онд Монголд ирж жүжигчдийн сонгон шалгаруулалтаа хийсэн бөгөөд жүжигчин Н.Ялалтыг киноныхоо гол дүрд тоглуулсан гэдэг. Дээрх кино наадам өнөөдөр албан ёсоор эхэлж байгаа бөгөөд Г.Ялалттай хамт жүжигчин Д.Батцэцэг, Б.Бат-Ирээдүй, Т.Энэрэл нарын уран бүтээлч оролцох гэнэ. ■



ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ
ХАМГИЙН БАГА ХҮҮ

Интернэт банкаар зээлээ ав

1800-1800 | www.ubcbank.mn

← 1

Шинээр халдвар авсан хүмүүсийн 30 нь Сөүл хотоос 300 км зайтай оршдог Дэгү хотын оршин суугчид бол 31 дэх тохиолдол нь Сөүлд бүртгэгдлээ. Шинэ тохиолдлын 23 хүн 31 дэх халдвар тээгчтэй нэг сүмд явдаг байж. Мөн хоёр хүн эмнэлэгт халдвар авсан бол үлдсэн тав нь ямар замаар халдварт өртсөн нь одоогоор тодорхойгүй байна. Халдвар тээгч 31 дэх тохиолдол нь 61 настай эмэгтэй бөгөөд гадаадад аялсан түүхгүй, вирусийн халдвар тээгчидтэй ойр байгаагүй гэж асуумжид хариулжээ. Уг эмэгтэй нийгмийн эрүүл мэндийн төвд үзлэгт хамрагдаж, коронавирусийн шинжилгээ өгсөн бөгөөд ямар замаар халдварласан нь тодорхойгүй байгаа юм. **Халдвар тээгчийн очдог сүмийн пасторынх нь хэлснээр мөргөлийн үеэр 1000 орчим хүн цугларсан байжээ. Тиймээс цааш халдвар тараасан байх эрсдэлтэй тул Өмнөд Солонгосын эмнэлгийн байгууллагынхан мөшгиж, тандалт хийж байгаа аж.**

Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр, БНСУ-д коронавирусийн халдвар авсан 16 хүн эдгэрч, 66 хүн эмчилгээг үргэлжлүүлж байна. Мөн сэжигтэй 1633 тохиолдол бүртгэгдсэн ба өдөр бүр 800-1000 хүнд коронавирусийн шинжилгээ хийж байна гэж тус улсын Эрүүл мэндийн яамнаас мэдээлжээ. Түүнчлэн нөхцөл байдал төвөгтэй болж байгаа учраас өдөрт 10000 хүнээс шинжилгээ авахаар шийдвэрлэж буй аж.

Тус улсад 47000 монгол ажиллаж, амьдарч байна. Зөвхөн өнгөрсөн сард л гэхэд БНСУ руу манай 34000 хүн агаарын тээврээр зорчжээ. Түүнчлэн визийн хугацаа

COVID-19-ийн халдвар Солонгосоос орж ирэх аюул нүүрлэлээ

Тус улсад 47000 монгол ажиллаж амьдарч байна. Зөвхөн өнгөрсөн сард гэхэд БНСУ руу манайхаас 34000 хүн зорчжээ



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

хэтрүүлж, хууль бусаар амьдарч буй хүмүүс ч цөөнгүй бий. Тэд эх орондоо вирус тээгээд ирэхийг ч үгүйсгэхгүй аюултай нөхцөл байдал үүслээ. Иймээс улсынхаа иргэдийн тандалтыг сайн хийж, мэдээллийг нягтлах, хил гаалийн хяналтаа улам сайжруулах шаардлага

манай улсын өмнө тулгарлаа. Монголоос БНСУ-д суугаа ЭСЯ-ны Консулын хэлтсээс иргэддээ хандаж анхааруулга гаргасан байна. Хэрэв өндөр халуурах, ханиалгах, дотор муухайрч огих зэрэг шинж тэмдэг илэрсэн тохиолдолд БНСУ-ын Халдварт өвчин судлалын төвийн 1339 (24

цагаар ажиллана), Цагаачлалын албаны 1345 дугаарт залгаж болно. Энэ нь утас руу 09.00-22.00 цагийн хооронд залгасан тохиолдолд монгол хэлээр хариулт өгнө. Мөн ойролцоох эмнэлгийн байгууллагад хандаарай хэмээн зөвлөжээ. БНСУ дахь нөхцөл байдлын

талаар тус улсын Халдварт өвчин судлалын төвийн <http://ncov.mohw.go.kr> цахим хуудаснаас албан ёсны мэдээ, мэдээлэл авах боломжтой.

Мөн өвчний тархалтын нөхцөл байдал болон Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар ЭСЯ-ны Консулын хэлтсийн 02-798-1950 дугаарын утас, www.mongolembassy.com цахим хуудас болон “Embassy of Mongolia in Seoul” фэйсбүүк хуудаснаас мэдээлэлтэй тогтмол танилцаж болохыг зөвлөж байна.

ТЭНД АМЬДАРЧ БУЙ МОНГОЛЧУУД ХАРЬЦАНГУЙ ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ САЙТАЙ ГАЗАР БАЙГАА НЬ ОЛЗУУРХУУШТАЙ.

Тэнд амьдарч буй монголчууд харьцангуй оношилгоо, эмчилгээ сайтай газар байгаа нь олзуурхуштай. Тиймээс эх орон руугаа ирэх гэж яарахаас өмнө өөрийн биеийн байдлаа ажиглаж, ядаж халдварын нууц үеийн 21 хоногийг өнгөрөөх нь ах дүү нараа, элгэн саднаа бодсон хүн чанартай хэрэг болох буй за. Өндөр хөгжилтэй улс орнууд COVID-19 халдварын өмнө барьц алдаж, тэвдэж байхад Монгол руу өвчин чирээд ирвэл хэцүүхэн асуудал тулгарна гэдгийг сануулахад илүүдэхгүй биз ээ. Тиймээс ДЭМБ-ын зөвлөмжийг санаж, маскаа тогтмол зүүж, гараа сайн угааж, хувийн дэглэм сайн мөрдөх нь өөрийгөө болоод өрөөлийг халдварт өвчнөөс хамгаалахад тусална гэдгийг умартаж болохгүй. ■

Газраа чөлөөлсөн айлууд Хулгана жилийн босгон дээр байрны түлхүүр гардлаа

Улаанбаатар хотод анх удаа газрыг бэлэн орон сууцаар сольж байна. Энэ нь гэр хорооллыг орон сууцжуулах төсөл хөтөлбөрүүдэд шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлж буйгаараа онцлогтой. **Эхний ээлжинд Сонгинохайрхан дүүргийн IX хороо буюу Баянхошуу орчмын 5.2 га газарт дөрвөн гудамжны 310 гаруй иргэн нэгдэн, газраа чөлөөлөх хүсэлтээ НОСК-д илэрхийлжээ. Ингэснээр тэд орон сууцтай болж байгаа бөгөөд сар шинийн босгон дээр шинэ байрныхаа түлхүүрийг гардаж авлаа.** Уг арга хэмжээний үеэр Нийслэлийн Засаг дарга С.Амарсайхан “Нийслэлд орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ орлогод нийцсэн, айл өрхийн амьжиргаа, төлбөрийн чадварыг уян хатан байлгах зорилгоор түрээслэх,



Гэрэл зургийг С.Батсайхан

түрээслээд өмчлөх, худалдан борлуулах гэсэн олон сонголтыг иргэддээ санал болгож байгаа. Мөн тухайн иргэний газар дээр байгаа амбаараас эхлээд хүний гараар бүтээсэн бүхий л объектийг үнэлсэн” хэмээн онцоллоо. **Сонгинохайрхан дүүргийн IX**

хорооныхон газраа чөлөөлж өгөөд “Буянт-Ухаа 2” хороололд 2-3 гурван өрөө байртай болсон бөгөөд газрын үнэлгээ, байрны үнэлгээнээс гарсан зөрүү мөнгийг таван жилийн хугацаанд найман хувийн хүүтэй зээлээр төлөх юм байна. ■

Завхан болон Улаанбаатарт тус бүр нэг иргэнийг тусгаарлажээ

Коронавирусийн тархалтын талаар Эрүүл мэндийн яам цаг үеийн асуудлаар ээлжит мэдээллээ хийлээ. Монгол Улсад энэ халдвар бүртгэгдээгүй ч зөөвөрлөгдөн орж ирэх өндөр эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарчээ. Хэрэв халдвар бүртгэгдвэл тархах өндөр эрсдэлтэй гэдгийг салбарын яамнаас анхааруулж байна. Тиймээс удахгүй болох сар шинийн баяраар айл бүр гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлж чадвал аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтойг зөвлөлөө. ХӨСҮТ-ийн мэдээлснээр коронавирусийн сэжигтэй 170 гаруй тохиолдол бүртгэгдээд

байна. Хурлын үеэр ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны дарга А.Амбасэлмаа **“Завхан аймагт нэг сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн тул тусгаарлалаа. Тухайн хүн Гашуунсухайт боомтоор БНХАУ-руу хоёрдугаар сарын 6-12-ны хооронд зорчоод ирсэн, халуурсан, хатгааны шинж тэмдэгтэй байсан. Завханы иргэнтэй хамт автобусанд явсан 40 хүнийг хамгаалалтад авсан. Мөн ХӨСҮТ-д нэг иргэнийг тусгаарлалаа. Тус иргэн Хятадын Тяньжинь хотод сурдаг оюутан. Хоёрдугаар сарын 13-нд Бээжин-Улаанбаатарын нисэх онгоцоор ирсэн”** гэв. ■

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Б.Гарьд, ЗГМ сонин

Дэлхий даяар корона-вирусээс ард иргэдээ хамгаалахаар төрөл бүрийн хориг, хязгаар тогтоож байгаа энэ цагт манай улс ч гэсэн “бөөгнөрөөд яахав дээ, бөөн вирус” уриан дор халдвараас сэргийлэхээр хичээж, COVID-19-өөс хамгаалах олон арга хэмжээ авч байна. Харин халдвар дамжих өндөр эрсдэлтэй нэг салбарыг Улсын онцгой комисс орхичихлоо. Тэр нь баар, ресторан, караоке зэрэг хүмүүс олноороо цугладаг газрууд юм.

Нийслэлийн хэмжээнд архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг 2400 гаруй аж ахуйн нэгж, байгууллага бий. Үүнээс 198 нь баар, шөнийн клуб, 491 ресторан, зоогийн газар, 424 караоке, 429 кафе, паб хүн цуглуулж согтууруулах ундаагаар үйлчлэх

зөвшөөрөлтэй. **Баянзүрх дүүрэгт гэхэд л 152 ресторан, 196 баар, караоке, 51 кафе ажиллаж байна. Зөвхөн Сансарын тунель орчимд, 500 метрийн радиуст 42 баар, караоке байгаа юм. Тэнд нэг орой үйлчлүүлдэг хүний тоо томоохон урлаг, спортын арга хэмжээнд цугладаг үзэгчийн тооноос хол давна.** Урлаг, спортын арга хэмжээг цуцалсан мөртлөө ууж наргихаар бөөгнөрөх үйлдлийг хориглоогүй нь учир зүйн хувьд дутагдалтай байдлыг бий болгож байна.

Уг нь Нийслэлийн Засаг дарга шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамж гаргаж, баар, ресторан, караокены ажиллах

цагийг дөрвөөр багасгасан ч үр дүнд хүрэхгүй байх магадлал өндөр байна. Энэ байдал Цагаан сарын үеэр бүр ч нэмэгдэх хандлагатай. **Сар шинийн баярын үеэр улс даяараа тав хоног амрах учраас уйдсан залуус, уулзаж учрах сонирхолтой иргэдийн хөдөлгөөн баар, ресторан, караоке тийш хөврөх нь. Мөн Улсын онцгой комиссоос орон нутагт зорчих хөдөлгөөнийг хязгаарласан тул залуусын орох, цуглах газар нь баар, караоке болох шинж цухалцаж эхэллээ.** Спирт хэрэглэвэл вируст өртөхгүй гэх цуурхал ч залуусын ууж наргих сонирхол өдөөж байгааг дурдахад илүүдэхгүй.

Цагаан сарын өдрүүдээр нэг бааранд үйлчлүүлэх хүний тоо ганц хөгшинд золгох зочдын тооноос илүү гарах нь тодорхой учраас золголтын хөдөлгөөнийг хянах нь утгагүй санагдахыг хэлэх юун. Дунджаар нэг баар өдөрт 100

гаруй хүнд үйлчилдэг гэж тооцвол нийслэл дэх энэ олон баар, караокед хэчнээн хүн цуглах нь тодорхой. Нийтээр нь авч үзвэл аймаг сумын наадамтай дүйцэх тоо гарч байна. Гэтэл бид 30 гаруй багштай сургууль, цэцэрлэгт цуглахыг хориглож, зөрчсөн удирдах албан тушаалтныг суудлаас нь үг дуугүй огцруулах шийдвэр гаргаад байгаа биш билүү. Энэ үүднээс нь дүгнэвэл олон зуун сургууль, цэцэрлэг багш нараа цуглуулсны хэмжээтэй үйл ажиллагаа баар ресторанд өрнөх нь. Өөрөөр хэлбэл, караокед арзганаж, бааранд бужигнаж байгаа цагт коронавирусийн аюул хэвээр байна гэсэн үг. Тиймээс **өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд баар, караоке зэрэг олон хүн нэг дор цугладаг газрын**



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

Караокед арзганаж, бааранд бужигнаж байгаа цагт коронавирүс тархах аюул хэвээр

Залуусыг бааранд бус гэрт нь “уях” аргыг хэрэгжүүлэх олон боломж байна

үйл ажиллагааг хориглох нь зөв юм. Эсвэл ядахдаа Цагаан сарын баярын үер баар, рестораны үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргах хэрэгтэй. Энэ нь нэг талаар худалдаа, үйлчилгээний салбарын орлогыг багахан хувиар бууруулах ч хүний амь нас, эрүүл мэндээс илүү үнэлэгдэх ашиг хонжоо байж таарахгүй. Мөн хүний хэрэглээ, хүсэл сонирхлыг боогдуулж болохгүй ч нэгээс нийтийн эрх ашиг хамаарах зайлшгүй шаардлагыг харгалзан сар тэвчих, ядахдаа олон нийтийн газар цуглаж уухгүй байхыг нөхцөл байдал шаардаж буй юм.

Үзвэр үйлчилгээг хаасан энэ үед залуусыг “эрхлүүлэх” өөр олон аргыг санаачилж болно шүү дээ. Тухайлбал, **телевизийн төлбөрт сувгуудыг нээж, кино, тв контентыг үнэгүй болгохоос эхлээд үүрэн телефоны операторуудтай хамтран интернэт номын үйлчилгээг өргөн хүрээнд нэвтрүүлж яагаад болохгүй гэж.** Мөн дэлхийн спортын сонирхолтой уралдаан тэмцээн дамжуулах эрхийг худалдан авч телевизээр гаргавал бааранд орох сонирхолтой олон залуусыг гэрт нь “уях” боломж бий. Үүний зардлыг COVID-19 вирусээс

сэргийлэхээр төрөөс зарцуулж буй төсвийн хөрөнгөд ч шингээж болно. Энэ мэтчилэн “хийх хүн аргаа олдог, хийрхүү хүн шалтаг тоочдог” гэсэн зарчмаар сэтгэж чадвал олон боломж байна. Энэ дашрамд нэг зүйлийг санал болгоход муслим шашинтны нэг сарын турш архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй Рамадан сарын уламжлалыг нөхцөл байдлын шаардлагаар монгол үндэстэн ганц удаа хэрэглэхэд бас яагаад болохгүй гэж. Уриалга гаргаад ухуулга хийж чадвал олны хөдөлгөөнийг хязгаарлахад нэмэр болох магад. ■

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.02.21

Тендер шалгаруулалтын нэр: Бохир усны насос нийлүүлэгчийг сонгон шалгаруулах /багцтай/.
Тендер шалгаруулалтын дугаар/гэрээний дугаар: УСУГ-ХА-2020-17

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **бохир усны насос нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай** цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 3 жилд буюу 2017, 2018, 2019 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 3 жил /2017, 2018, 2019/ тус бүр тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 100 хувиас дээш байх.

Нэг оролцогч тухайн тендерийн 1 багцад санал ирүүлнэ. Хэрэв 2 дахь багцад санал ирүүлсэн тохиолдолд түүнийг үнэлэхгүй болохыг анхаарна уу.

Тендерийн хамт

Багц-1 10,000,000.00 /арван сая/ төгрөг,

Багц-2 1,900,000.00 /нэг сая есөн зуун мянган/ төгрөг,

Багц-3 1,100,000.00 /нэг сая нэг зуун мянган/ төгрөгний тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: **2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийг дуустал.**

Тендерийг **2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 10 цаг 30 минут-аас** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР, ТОКИОГИЙН ГУДАМЖ-5, ӨӨРИЙН БАЙР, Р.БАТСҮРЭН УТАС: 70157018-121

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.02.21

Тендер шалгаруулалтын нэр: Химийн бодис нийлүүлэгчийг сонгон шалгаруулах /багцтай/.
Тендер шалгаруулалтын дугаар/гэрээний дугаар: УСУГ-БМ-2020-25

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **химийн бодис нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай** цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 3 жилд буюу 2017, 2018, 2018 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

Борлуулалтын орлого нь сүүлийн 3 жил /2017, 2018, 2019/ тус бүр тухайн багц тус бүрийн төсөвт өртгийн 100 хувиас дээш байх.

Нэг оролцогч тухайн тендерийн 1 багцад санал ирүүлнэ. Хэрэв 2 дахь багцад санал ирүүлсэн тохиолдолд түүнийг үнэлэхгүй болохыг анхаарна уу.

Тендерийн хамт

Багц-1 21,950,000 /хорин нэг сая есөн зуун тавин мянган/ төгрөг,

Багц-2 10,500,000.00 /арван сая таван зуун мянган/ төгрөг,

Багц-3 360,000.00 /гурван зуун жаран мянган/ төгрөгний тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Хүчинтэй байх хугацаа: **2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийг дуустал.**

Тендерийг **2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 11 цаг 30 минут-аас** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

ХАЯГ: УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР, ТОКИОГИЙН ГУДАМЖ-5, ӨӨРИЙН БАЙР, Р.БАТСҮРЭН УТАС: 70157018-121



Энэ жил 200 ууцтай ирсэн. Бүтэн сар зогсоод дөнгөж 100-г зарлаа. Үлдсэнийг нь жижиглээд зарна даа. Ер нь энэ жил кг-ын мах үнэтэй, ууц харьцангуй хямд байна гэв.

📷 Гэрэл звөггийг С.Батсайхан

Хорьсон ч тэмдэглэнэ, хориогүй ч тэмдэглэнэ

Айл хэсэхдээ маск зүүж, гараа сайн ариутгавал гайгүй байлгүй дээ. Тэгээд ч коронавирус Монголд орж ирсэн нь батлагдаагүй байхад ингэж сүржигнэх хэрэг байгаа юм уу” хэмээн ярих нэгэн ч байна

✍ Б.Энхжин, ЗГМ сонин

Сар шинийн баяр дөхсөн энэ өдрүүдэд зах дэлгүүрүүд олны хөлд дарагдаж, ёстой л түм түжигнэж, бум бужигнадаг. Харин халдварт өвчин дэгдэх эрсдэл бүхий онцгой энэ үед байдал ямар байгааг сурвалжиллаа.

Мах, ууц, цагаан идээ хамгийн хямд үнэтэй байдаг “Хүчит шонхор” зах үеийн үед олны хөлд дарагддаг. Энэ жил хөл хөдөлгөөн харьцангуй бага байгааг захынхан тайлбарлаж байлаа. “Өмнө нь цагаан сарын үеэр энэ хавийн зам ачааллаа дийлэхээ больж, нэг урсгалтай болгодог байсан. Харин одоо бол сэлүүхэн байгаа биз дээ” хэмээн орж буй машинд тасалбар өгдөг залуу өгүүлэв.

Гэхдээ л зах дотор машинууд багталцаж ядан хөлхөж байлаа. Ууцны борлуулалт хэр байгааг сонирхохоор махны худалдаачид дээр очив. Ерөнхийдөө худалдан авагчаасаа олон худалдагч байгаа харагдана. Ууцны борлуулалт янз бүр л байгаа бололтой. Дорноговиос ирсэн Б.Бат-Амгалан “Ах нь энэ жил 200 ууцтай ирсэн. Бүтэн сар зогсоод дөнгөж 100-г нь зарлаа. Үлдсэнийг нь Цагаан сарын дараа жижиглээд зарна даа. Ер нь энэ жил кг-ын мах үнэтэй, ууц харьцангуй хямд байна. Бид нар ууцаа борлуулахын тулд 20-30 мянган төгрөг хямдруулаад өгч байгаа” гэв.

Тэгвэл Дундговийн Дэлгэрхангайгаас ирсэн Ч.Хатанбаатар борлуулалт давгүй гэдгийг хэлэв. “Нутгаасаа 200 ууцтай ирсэн. Одоо хэдхэн

“НАРАНТУУЛ”-ЫН УДИРДЛАГУУД ТҮРЭЭС НЭХЭХДЭЭ ГАРАМГАЙ МӨРТЛӨӨ АРИУТГАЛ ХАЛДВАРГУЙ-ЖҮҮЛЭЛТ ГЭЖ ЮУ Ч ХИЙДЭГГҮЙ. ЭНЭ АЙХТАР ӨВЧИН ДЭГДСЭНЭЭС ХОЙШ МАНАЙ ЭНЭ ХАВЬД ЛАВ ЯМАР Ч АРИУТГАЛ ХИЙГЭЭГҮЙ” ХЭМЭЭН “ХОВЛОЛОО”.

үлдчихлээ. Өглөө ирээд есийг зарчихлаа. Энэ хэдийгээ зарж

дуусаад нутаг буцна даа” хэмээн яриу.

Өмнө нь хүмүүс сүртэй том ууц сонирхдог байсан бол энэ жил эсрэгээрээ эргэжээ. Тухайлбал, 120-150 мянган төгрөгийн үнэтэй төлөгний ууц хамгийн сайн борлуулалттай байгааг тэд учирлаж байв. Өдгөө жижиг ууцнууд бараг зарагдаж дуусаад том хэд нь л үлджээ. Ерөнхийдөө ууц 150-380 мянган хооронд зарагдаж байлаа.

Цагаан идээ, хэвийн боовны борлуулалт ч огцом багасчээ. Тус захад цагаан идээ борлуулаад долоон жил болж буй н.Насанжаргал “Ёс юм болохоор хүмүүс цагаан идээ авч л байна. Гэхдээ өмнөх жилүүдийн борлуулалтыг яаж гүйцэв. Татсан барааны 60, 70 хувь нь үлдсэн. Үлдсэнийг нь хаврын уртад зарж

дуусгана даа. Хатуу ааруул ч яахав муудна гэж санаа зовохгүй. Харин муудаж, хөгцөрдөг хэдийг нь яах вэ гээд гайхаж сууна” хэмээн яриу.

Хэвийн боов зарж буй бүсгүйчүүдээс борлуулалт ямар байгааг сонирхоход “Чи тавлаад байна уу” хэмээн загнуулах нь тэр. “Чи өөрөө харж байгаа биз дээ. Хүн ерөөсөө алга. Урьдынх шиг 20, 30-аар нь авдаг хүнгүй болсон. Хүмүүс ихэвчлэн есөн ширхэгийг авч байна. Зарим нь бүр гурван боовоор таваг засна гээд авдаг. Худалдан авалтдаа тааруулаад бага хэмжээгээр захиалж байгаа” хэмээн тэд учирласан юм. Борлуулалт тааруухан болоод ч тэр үү, хэвийн боовны үнэ өнгөрсөн жилтэй харьцуулахад хямд байлаа. Тус захад зарагдаж буй боов хэлбэр хийц, үйлдвэрээсээ хамаараад 1200-3000 төгрөгийн

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН
Ерөнхий эрхлэгч
Баатарын Дуламхорлоо
Зөвлөх
Шатарбалын Даваадорж
Орлогч эрхлэгч
Лхагважавын Сугармаа
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Г.Баяртогтох
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ДУГААРЫН УДИРДАГЧ

Л.Сугармаа

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА
Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
✉ **INFO@ZASAG.CO**
Утас: 99903584 хаагаар бидэнтэй холбогдоно уу.

ЭДИЙН ЗАСАГ

- ☉ Монголын компаниудын маркетинг олон улсын түвшнээс 50 хувийн хоцрогдолтой байна → 9
- ☉ Л.Хангай: “Айлчлал сайхан боллоо” гээд санаа амарч, тайвширч болохгүй → 10

- ☉ Суртал ухуулга иргэдийг хилэгнүүлжээ → 11
- ☉ “Роснефть”-д тогтоосон хориг газрын тосны үнийг тогтворжууллаа → 11

ЗГМ: ТОВЧХОН

■ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 30 компанийн 390,176 ширхэг хувьцаа арилжлаа.

■ ИНДЕКС

0.21

Хувь. ТОП 20 индекс 0.21 хувиар өсөж, зах зээлийн үнэлгээ 2.7 их наяд төгрөг боллоо.

■ НОГДОЛ АШИГ

21.5

Сая төгрөг. “Хөвсгөл Геологи” компани 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 150 төгрөг, нийт 21.5 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.

■ МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

201.4

Тэрбум төгрөг. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны нэгдүгээр сарын эцэст 837.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 201.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

■ БАНК, САНХҮҮ

10.9

Хувь. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл энэ оны эхний сарын эцэст 925.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувийг эзэлж байна.

■ ТӨСӨВ

79.5

Хувь. Улсын төсвийн орлогын 79.5 хувийг татварын орлого, 9.6 хувийг татварын бус орлого, 10.7 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.2 хувийг тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж байна.

■ ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцэл 2018 онд 141.7 сая ам.долларын алдагдалтай байсан бол 2019 онд 452.9 сая ам.долларын ашигтай гарав.



Гэрэл зургийг С.Батсайхан

Төмөр зам барих эсвэл төсвийн алдагдлаа нөхөх сонголт байна

“Эрдэнэс Тавантолгой”-н нийт хувьцааны 85 хувийг төр эзэмшдэг

✍ Б.Баяртогтох, ЗГМ сонин

“Эрдэнэс Тавантолгой” компани 2019 оны цэвэр ашгаасаа хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараах болсноо зарласан нь энэ долоо хоногийн чухал үйл явдлын нэг байлаа. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж, нэгж хувьцаанд 90 төгрөг олгохоо мэдэгдэж, 1072 хувьцаатай иргэнд 96,480 төгрөг ногдож байгаа юм. Нийт 150 гаруй тэрбум төгрөг иргэн, аж ахуйн нэгжид ногдол ашиг болж хүрнэ. Үүний хэд нь хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт болж, хэчнээн нь импортыг тэтгэх эсэхийг хэлж мэдэхгүй юм.

Эргэн сануулахад, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргахаар төлөвлөж буй тус компани 2019 онд нэг тэрбум ам.долларын борлуулалт хийж, нэг их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Түүхэнд анх удаа ийм өндөр ашигтай ажилласан нь энэ. Үүний 150 гаруй тэрбум нь 1072 хувьцаа эзэмшигчдэд ногдож байгаагаас үзвэл, төрд 800 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг оногдохоор байна. Үүгээр Засгийн газар төмөр зам барих эсвэл төсвийн алдагдлаа нөхөх

800 ГАРУЙ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШГАА ЮУНД ХЭРХЭН ЗАРЦУУЛАХ НЬ ТОДОРХОЙ БУС БАЙНА. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н 2018 ОНЫ ЦЭВЭР АШИГ БОЛОХ 700 ГАРУЙ ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛД ЗАРЦУУЛСАН. ЭНЭХҮҮ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ДАХИАД Ч ЭНЭ ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГӨ МӨНГӨ ДУТАГДАЛТАЙ БАЙГАА.

эсэхээ шийдэх үлдлээ. Сангийн дэд сайдаас 1072 хувьцааны ногдол ашгаар төсвийн алдагдлыг нөхөх эсэх тухай асуусан боловч одоогоор ийм асуудал яригдаагүй байгаа гэв. Харин Сангийн сайд Ч.Хүрэлбаатар 2020 оны төсвийн орлого нэг их наяд төгрөгөөр дутах эрсдэл байгааг дуулгасан юм.

Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд зааснаар хувьцаа эзэмшигчдэд

ногдол ашиг тараах тухай шийдвэр нь төр, иргэн, аж ахуйн нэгж гэж ялгагдаггүй. Шийдвэр аль алинд нь тэгш үйлчилдэг. Тэр жишгээр төр ногдол ашгаа авахаа мөн илэрхийлсэн. Харин 800 гаруй тэрбум төгрөгийн ногдол ашгийг юунд хэрхэн зарцуулах нь өнөөдөр тодорхой бус байна. “Эрдэнэс Тавантолгой”-н 2018 оны цэвэр ашиг болох 700 гаруй тэрбум төгрөгийг төмөр замын төсөлд зарцуулсан. Энэхүү бүтээн байгуулалтад дахиад ч энэ хэмжээний хөрөнгө дутагдалтай байгаа. Төр хүсвэл ногдол ашгаасаа татгалзаж болох юм. Ийм тохиолдолд төсвийн алдагдал нөхөх бус төмөр замын төслөө урагшлуулах эсвэл компани шаардлагатай байгаа баяжуулах үйлдвэр барих зэрэг бүтээн байгуулалтад хөрөнгө зарах сонголт байна. Төр өөрийн ногдол ашгаа хэдэн хувийг нь зарцуулахыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэх нь ойлгомжтой. “Эрдэнэс Тавантолгой”-н компаниас төр өөрт ногдох ногдол ашгаа юунд зарцуулах эсэхийг тодруулсан боловч гүйцэтгэх захирал Б.Ганхуяг эзгүй байгаа учраас өчигдөр тодорхой хариулт өгч чадсангүй. Тус

компани өнөөдөр хэвлэлийн хурал хийхээр товлосон байлаа.

“Эрдэнэс Тавантолгой”-н нийт хувьцааны 15 хувийг иргэд, аж ахуйн нэгж эзэмшиж буй. Хувьцаа эзэмшигч 2.5 сая иргэний 1.8 сая нь хувьцааны дансаа нээлгэжээ. Үлдсэн 600 мянга нь ирэх тавдугаар сараас өмнө хувьцааны дансаа нээлгэх шаардлагатай болж байна. 1072 хувьцааг бусдад зарж борлуулах, шилжүүлэх, өвлүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй бөгөөд сонгодог утгаар нь хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн гэж үзэх боломжгүй. Зөвхөн эрхийн бичиг төдий байгааг Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай өгүүлсэн юм.

“1072 хувьцаа одоо амилаагүй, хаалттай байгаа болохоор өв залгамжлах эрх нээгдээгүй. Монголын хөрөнгийн зах зээлд манай хувьцаа арилжаалагдаад эхэлсэн үед нас барсан иргэний хувьцааг шилжүүлэх эрх үүснэ” гэж “Эрдэнэс Тавантолгой” компанийн “1072 мэдээллийн алба”-ны ажилтан Э.Баатарцогт ярьсан юм. Засгийн газрын 2011 оны 116 дугаар тогтоолоор хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж эхлэх хүртэл бусдад шилжүүлэхийг хориглосон билээ. ■

Монголын компаниудын маркетинг олон улсын түвшнээс 50 хувийн хоцрогдолтой байна

Үр өгөөжөө хэмжиж чаддаггүй ч маркетингийн үйл ажиллагааны зардлаа 65 хувь нь өсгөнө гэжээ



Гэрэл зургийг С.Батсайхан

Э.Батцэцэг, ЗГМ сонин

Үндэсний судалгааны Mongolian Marketing Consulting Group, Bloomberg TV Mongolia хамтран ТОП 50 компанийн гүйцэтгэх захирлуудын дунд CEO survey 2020 судалгаа хийжээ. Уг судалгааны нэг хэсэгт Монголын компаниуд маркетингийн асуудалд хэрхэн анхаардгийг онцолсон байна. CEO нарын үзэж байгаагаас компанийн амжилтын гол хүчин зүйл, бизнесийн цөм, зах зээлээ тэлэх боломж, цаашлаад компанийн оршин тогтнох үндэс болсон маркетингийн үйл ажиллагаа Монголд хангалттай биш байгааг тодорхойлж болохоор байна. Дэлхийн дунджаар компаниуд борлуулалтын орлогынхоо 11 орчим хувийг маркетингдаа зарцуулдаг байхад манайд 5.7 хувь буюу бараг хоёр дахин бага төсөв хуваарилдаг аж. 2018 онд маркетингийн албаны дарга нарын дунд явуулсан судалгаанд


ТОП 50 компани нийт 75 орчим тэрбум төгрөгийг маркетингдаа зарцуулдаг гэж дурджээ. Энэ нь дунджаар нэг компани 1.5 тэрбум төгрөг зарцуулдаг гэсэн үг юм. Харин таван тэрбум төгрөгөөс дээш хөрөнгийг маркетингийн үйл ажиллагаандаа зарцуулдаг компани судалгаанд оролцогчдын ердөө 10 хувийг эзэлж байжээ. Гүйцэтгэх захирлуудын 65 хувь нь 2020 онд маркетингийн зардлаа өсгөнө гэж тооцоолж байгаа аж. Энэ

ТАВАН ТЭРБУМ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ХӨРӨНГӨ МАРКЕТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ЗАРЦУУЛДАГ КОМПАНИ СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРДӨӨ 10 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙЖЭЭ.

Маркетингийн алдаа (ТОП 50 CEO-ийн хүрээнд явуулсан судалгаа)



Компаниудын борлуулалтын орлогод маркетингийн зардлын эзлэх хувь (дэлхийд, Монголд)



нь эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй энэ жилийн хувьд компанийн өсөлтөө хадгалах зорилготой бодлого юм.

Гэвч судалгаанд оролцогчдын 71 хувь нь маркетинг, олон нийтэй харилцах ажлын үр дүнгээ бүрэн хэмждэггүй, зар сурталчилгаа, кампанит ажлын өгөөж хэрхэн хүрч байгааг судалж гаргаж чаддаггүй гэжээ. Тиймээс сайжруулах арга замаа тодорхойлох боломжгүй байдгаа мөн учирлажээ. Харин олон улсад зар сурталчилгааны ажлын үр дүнг цогц үзүүлэлтээр хэмжих монито-

рингийн дэвшилтэт загвар байдаг. Энэ нь зардлаа өсгөхгүйгээр кампанит ажлуудын үр өгөөжийг нэмэгдүүлдэг ач холбогдолтой. Үүнийг зар сурталчилгаа нийлүүлэгч компаниуд томоохон кампанит ажлын дараа, эсвэл улирал тутам хийж өгдөг. Гэтэл Монголын ТОП 50 компанийн дунд явуулсан судалгаанаас харахад мониторингоо сайжруулахгүйгээр зардлаа нэмэгдүүлнэ гэж байгаа нь маркетингийн үр өгөөжгүй процессоо өөрчлөх сонирхолгүй байгааг илтгэж байна. ■

SONY

BRAVIA
OLED

Дүү, дүрслэлд автуулна.

Sony брэндийн BRAVIA OLED зурагт нь шинэ процессор болон дэлгэцнээс дүү үүсгэх технологийг агуулснаараа онцлог. Кино театрын мэт бодит дүрслэл, өндөр чанартай дуугаралтыг танд хүргэнэ.

Утас: 7722-0272
www.bsb.mn

Better Lifestyle



Н.Анир, ЗГМ сонин

Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг өнгөрсөн оны 12 дугаар сард ОХУ-д айлчлах үеэр Монголын нутгаар дайруулан БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх хоолой барих асуудал яригдсан. ОХУ-ын “Газпром” компанийн тэргүүн А.Миллертэй манай Шадар сайд Ө.Энхтүвшин Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Санамж бичигт хүртэл гарын үсэг зурсан билээ. Монгол Улсаас ОХУ-д суух Элчин сайд асан Л.Хангайтай гурван орны эдийн засгийн коридор, хийн хоолойн асуудлаар ярилцлаа.



© Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

байгаагаа хэлсэн шүү дээ. Гэхдээ бид тайвширч болохгүй, шуурхай ажиллах хэрэгтэй. Энэ сарын 12-нд Казахстаны Эрчим хүчний сайд Н.Ногаев ОХУ-ын Эрчим хүчний сайд А.Новактай уулзахдаа Орос-Хятадыг холбох хийн хоолойг өөрийн нутгаар тавих сонирхолтой байгаагаа илэрхийллээ. Оросын сайд үүний өмнөхөн нь “Энергетическая политика” (Эрчим хүчний бодлого) сэтгүүлд өгсөн ярилцлагадаа хийн хоолойг Монголоор дайруулах хувилбарыг судалж байгаа гэсэн учир зөвшөөрсөн хариу өгөөгүй гэж найдаж байна. Энэ асуудал дээр манайхан Казахстанас



Л.Хангай: “Айлчлал сайхан боллоо” гээд санаа амарч, тайвширч болохгүй

-Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн айлчлалаас хойш хийгдсэн ажлын талаар ярилцлагаа эхлэх үү?

-Юуны өмнө аливаа өндөр, дээд хэмжээний айлчлалын дараа “айлчлал сайхан боллоо” хэмээн санаа амарч тайвширч болохгүй. Харин айлчлалын үеэр яригдсан, тохирсон зүйлүүдийг хэрэгжүүлэх их ажлын эхлэл гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Айлчлалаас хойш нэг сарын дараа буюу энэ оны нэгдүгээр сарын 6-нд Ерөнхий сайдын захирамжаар хийн хоолой барих төслийн

бэлтгэл ажлыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах үүрэг бүхий сайд, яамдын төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга нараас бүрдсэн ажлын хэсгийг Шадар сайд Ө.Энхтүвшингээр ахлуулан байгуулж, уг ажлын хэсэг нэг удаа хуралдсан сурагтай. Ийм ажлын хэсэг байгуулах хэрэгтэй

байх л даа. Гэхдээ сонгууль ойртоод дарга, даамал нар маань завтай байх уу, үгүй юу, сонгуулийн дараа өөрчлөгдөх үү, үлдэх үү гэдэг асуудлууд бас бий. Үүний зэрэгцээ хоёр талын хийх ажлыг тодорхой заасан Харилцан ойлголцлын санамж бичигт заагдсан хамтарсан ажлын хэсгийг нэн даруй байгуулж, ажилд нь оруулах хэрэгтэй. Санамж бичигт Оросын талаас “Газпром” компани гарын үсэг зурсан учраас уг хамтарсан ажлын хэсэгт манай

Эрхүү муж, Буриадын удирдлагуудтай байнгын нягт холбоотой ажиллах хэрэгтэй. Тэд хийн хоолой бариулах ажлыг манайхаас дутуугүй аль болох түргэн эхлүүлэх сонирхолтой.

талаас ч гэсэн аж ахуйн нэгжийн төлөөллийг голлон оролцуулвал илүү ажил хэрэгч болох ёстой.

-Манай талаас ямар аж ахуйн нэгж оролцох ёстой юм бол?

-Би нэг биш удаа ярьж, бичиж байгаа. “Эрдэнэс Монгол” компани шүү дээ. Яагаад гэвэл, уг компани төрийн өмчийнх. Хоёрдугаарт, Засгийн газарт шууд харъяалагддаг гуравдугаарт, Монголын бүх төрийн томоохон компаниудыг нэгтгэдэг. Бас олон улсад танигдсан төдийгүй тус компани томоохон төсөл хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалт татах зорилготой.

Чухам ийм компани л Оросын “Газпром”, Хятадын CNPC гэсэн дэлхийн хэмжээний аваргууд болон олон улсын банк-санхүүгийн байгууллагуудтай харилцана. Улс дамнасан хийн хоолой барина гэдэг төр, засгийн дэмжлэг, оролцоотой хэрэгждэг аварга төсөл хэдий ч

бизнес төсөл гэдгийг бодох хэрэгтэй. Саяхан ашиглалтад орсон “Сила Сибири-1” хоолой барих төслийг “Газпром” болон CNPC компани гэрээ байгуулан хэрэгжүүлсэн. Монголоор дайруулан хийн хоолой барих боломжийг судлахыг Ерөнхийлөгч В.Путин сайддаа биш, “Газпром” компанийн удирдлагад үүрэг болгосон нь ийм учиртай. Ер нь ажиглаад байхад манайд компанийн хийх ажлыг яам, яамны хийх ажлыг Засгийн газар нь хийгээд,

үүнээсээ болоод сүүлдээ асуудал болдог.

-Оросын тал ямар ажил хийж байгаа мэдээлэл байна уу?

-ОХУ манайхаар дамжин өнгөрөх хийн хоолой барих боломжийг судлах ажлыг зургаан сарын хугацаанд багтааж дуусгана гэж мэдэгдсэн. Өөрийн шаардлагатай гэж үзэж байгаа баримт бичгийн жагсаалтыг гаргаж, манай талд ирүүлсэн байна билээ. Мэдээж үүний дараа олон асуулт тавьж, янз бүрийн судалгаа шаардаж таарна. Бид дор дор нь хариу өгч байх ёстой. Бас зэрэгцүүлээд өөрсдийн жишээ нь, маршрутын талаар ч юм уу саналаа тавих хэрэгтэй. Энэ дашрамд дурьдахад, Эрхүү мужийн захиргаа хийн хоолойтой хамт нефтийн хоолой, эрчим хүчний шугам, төмөр болон авто замыг Байгаль нуурын баруун урдаас шууд Монголын хил хүртэл тавихыг санал болгодог юм. Яагаад гэвэл, ихээхэн дөт учраас асар их хөрөнгө хэмнэнэ. Судлах л хэрэгтэй байх. Нэмж хэлэхэд, бид хийн хоолойн талаар Эрхүү муж, Буриадын удирдлагуудтай байнгын нягт холбоотой ажиллах хэрэгтэй. Тэд хийн хоолой бариулах ажлыг манайхаас дутуугүй аль болох түргэн эхлүүлэх сонирхолтой.

-Хийн хоолойг нутгаараа дайруулснаар манай улс ямар ашиг хэрхэн хүртэх нь хамгийн чухал асуудал. Та энэ талаар юу гэж бодож байна?

-Манайхаар хийн хоолой дайран өнгөрвөл ямар хэмжээний өгөөж хүртэх боломжтойг дахин давтаад хэрэггүй байх. Харин тодруулж хэдэн зүйл хэлье. Нутаг дэвсгэр дээгүүрээ хийн болон нефть дамжуулах транзит

хоолой барьсан орнуудын туршлагаас үзэхэд үндсэн хоёр арга хэлбэр байдаг. Өөрийн нутгаар өнгөрөх хоолойг гадны хөрөнгөөр буюу компаниудаар бариулж, хий болон нефть дамжуулсны төлөө үнийн тодорхой хувийг төлбөр (Transit fee) болгон авдаг. Мөн өөрийн хөрөнгөөр буюу оролцоотойгоор хоолой барьж байгуулан ашиглалтыг нь хариуцан, дамжуулах тээвэрлэлтийн тариф (Transportation fee) тогтоож төлбөр авдаг. Бас өөр арга хэлбэр ч байдаг байх. Чухам ямрыг сонгохыг манай төр, засаг эдийн засгийн үр ашгийн тооцоо, өөрийн орны чадавх, аюулгүй байдлын асуудал зэргийг харгалзан шийдэх ёстой.

УЛС ДАМНАСАН ХИЙН ХООЛОЙ БАРИНА ГЭДЭГ ТӨР, ЗАСГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦООТой ХЭРЭГЖДЭГ АВАРГА ТӨСӨЛ ХЭДИЙ Ч БИЗНЕС ТӨСӨЛ ГЭДГИЙГ БОДОХ ХЭРЭГТЭЙ.

-Хийн хоолойг Монголын нутаг дээгүүр барина гэдэг бүтэцгүй зүйл гэх хүмүүс байна. Энэ талаар юу гэж хэлмээр байна?

-Хойд хөршийн төр, засгийн тэргүүн нар энэ асуудлыг судлана гэдгээ албан ёсоор мэдэгдсэн. Өмнөд хөршийн удирдлага ч гэсэн сонирхож

өрсөөд тохироо хийсэн гэж болно. Гэхдээ бид тайвширч болохгүй, шуурхайлах хэрэгтэй. Яагаад гэхээр энэ хоёр улс дэндүү ойр дотно харилцаатай. Бас нэгэн шинэ мэдээ хэвлэлээр гараад байна. ОХУ-ын “Газпром” компанийн тэргүүн А.Миллер өнгөрсөн 18-ны өдөр Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Давааг хүлээн авч уулзаад Монголын нутгаар дайруулан хийн хоолой барих төслийн талаар ярилцаж, хамтарсан ажлын хэсэг байгуулах асуудлаар санал солилцлоо. Түүнчлэн өөрийн охин компанийг Монголд байгуулах сонирхолтой байгаагаа ч хэлсэн байна.

-Та өөрөө энэ ажилд ямар оролцоотой байгаа вэ?

-Би Шадар сайдын болоод “Эрдэнэс Монгол” компанийн орон тооны бус зөвлөхөөр ажилладаг. Ямар нэгэн ажлын хэсэгт ордоггүй. Оросуудтай гайгүй харилцаатай байдаг. “Газпром” компани, уг компанийн судалгааны хүрээлэн болон бусад байгууллагын хүмүүстэй холбоотой. Жишээ нь, хийн хоолойн асуудлаар оросууд Монголд олон улсын хурал зохион байгуулах санал гаргасныг холбогдох дарга нарт танилцуулаад байна. Хятадад хэд хэдэн уулзалт, хуралд оролцлоо. Энэ бүгдийн тухай хэвлэлээр дамжуулан олон нийтэд хүргэхийг бас хичээж явдгаа хэлье. Хийн хоолой тавих, ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх, нормативуудыг боловсруулах, Орос, Хятадынхыг судлах гээд цаашид их ажил ундарч таарна. Энэ талаар сонирхогч байгууллагуудтай хамтарч ажиллах санаатай, яриа хэлэлцээ ч хийж байна. ■



Суртал ухуулга иргэдийг хилэгнүүлжээ

Тэмцлийн баатарлаг үйлсийн тухай жүжигчилсэн ухуулгад иргэд уярахаа больжээ

Covid-19 вирусийн халдвартай өвчтөн сувилахдаа үхлийн аюулт өвчнийг өөртөө халдахаас сэргийлэн урт хар үсээ тайруулж буй баруун умард Хятадын 14 эмэгтэй сэтгэл дотроо чимээгүй мэвшинэ.

Эрчүүд үсийг нь хусаж буй эмэгтэй сувилагч нарын видео бичлэгийг энэ сарын 15-нд Ганьсу мужийн эрх баригчдын дуу хоолой болдог Gansu Daily вэбсайтад тавьсан юм. Гэвч бүхнээ золиосолж буй эр зоригийн жишээ болох учиртай уг бичлэг сошиал медиад иргэдийн хилэнг бадраахаас хэтэрсэнгүй.

Онлайн орчинд шүүмжлэл дэгдэж, хоёрдугаар сарын 18-нд WeChat-аар “Эмэгтэйчүүдийн бие мах бодийг суртал ухуулгын хэрэгсэл болгохоо зогсоо” нэртэй материал тарсан юм. Гэхдээ тус сүлжээний хэрэглэгч нар устахаас нь өмнө 100 мянга гаруй хандаж амжжээ. Эмэгтэйчүүдийг суртал ухуулгын иймэрхүү кампанид албадан оролцуулж буй эсэх, үс хусах үйлдэл шинжлэх ухааны хэр үндэстэй вэ гэх мэт асуулт WeChat хэрэглэгчдийн дунд хөврөх

болов.

Онлайн шүүмжлэл ихэссэнтэй уялдан уг бичлэгийг Weibo дахь Gansu Daily-гийн аккаунтаас авч хаясан юм. Үсээ хусуулсан нь ажилтнуудын сайн дурын үйлдэл хэмээн видео бичлэгт гарсан сувилагч эмэгтэйчүүдийн ажилладаг эмнэлэг нь тайлбар өгөв. Дээрх шүүмж нь 2000 гаруй хүний аминд хүрээд буй вирусийн тархалттай холбоотой мэдээллийн ил тод байдал үгүйлэгдэж буйд хятад иргэд бухимдах болсны илрэл юм.

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЕ МАХ БОДИЙГ СУРТАЛ УХУУЛГЫН ХЭРЭГСЭЛ БОЛГОХОО ЗОГСОО”

Тэмцлийн баатарлаг эмчийн түүхээр хүн ардаа нэгтгэн нягтруулах Бээжингийн чармайлт явуургүй болж, харин анагаахын ажилтнуудыг хамгаалах арга хэмжээ учир

дутагдалтай, ажиллах орчин хахир хүнд байгааг сошиал сүлжээ хэрэглэгчид шүүмжлэх нь ихэссээр байна.

“Их Галт Хана” (Great Firewall) буюу Хятадын интернэт сүлжээний аварга шүүлтүүртэй систем дотоодын хэрэглэгчдийг Google, Facebook, Twitter зэрэг өрнөдийн мэдээллийн эх сурвалжид хандах боломж олгодоггүйгээс тус орны 1.4 тэрбум иргэний дийлэнх нь WeChat, Weibo зэрэг дотоодын платформ ашигладаг. Хэдийгээр цензурт өртөж устдаг ч, сүүлийн хэдэн долоо хоногт хятад иргэд дотоодын мэдээллийн платформ дахь төрийн мэдээллийн хэрэгслийн аккаунтуудыг шуурхай шүүмжилж амждаг болов.

“Хятад орон шинэ цаг үед шилжиж байна. Хүмүүс мэдээллийг хаанаас ч олж чаддаг болсон тул сайхан үлгэрээр бодит байдлыг өнгөлдөг үеэ өнгөрөөлөө. Суртал ухуулгын байгууллагууд шинэ нөхцөлийг бодож үзэх хэрэгтэй” хэмээн Наньжингийн их сургуулийн философи, хууль зүйн ухааны профессор Гу Су тайлбарласан юм. ■

McDonald's, Starbucks дахин ашигладаг савлагаа хөгжүүлж байна

Эмили Часан, Шинжээч

Уншигч та ирээдүйд McDonald's юм уу Starbucks-д кофе захиалах энэ үед өмнө өөрийн тань хаа нэгтээ ашиглаж байсан аяганд аягалж өгөх болно.

“Ухаалаг”, дахин ашигладаг, хоёр төрлийн аягыг энэ долоо хоногт хэрэглээнд нэвтрүүлэхээр туршиж эхлэх уг хөтөлбөрөөр АНУ-ын Калифорни муж улсын Сан-Франциско, Пало-Альто дахь кофе шопын олон сүлжээг ийм бүтээгдэхүүнээр хангах юм. Байрлалыг нь тодорхойлох үүднээс RFID чип юм уу QR код суулгасан, үндсэндээ хуванцар материалаар бүтээсэн

сөрөг нөлөөтэй. Иймд NextGen олон дахин ашигладаг, эдэлгээ сайтай аяга хийхэд гол анхаарлаа чиглүүлжээ. Энэхүү хүчин чармайлтын дүнд хүн төрөлхтөн цуглуулж, цэвэрлэдэг, дахин хуваарилж, дижитал технологийн тусламжтай хянахдаа, дахин ашигласан тоог, тодорхойлж болдог аяга хэрэглэх гэж байна.

Хоёр төрлийн шинэ аягыг энэ долоо хоногоос Калифорнийн кофе шопуудад туршиж эхэлнэ. Сан-Францискод Muuse стартапаас их дээд сургуулиудын кампуст турших аяга нь гаднаа QR кодтой бай юм. Хэрэглэгч уг аягыг хэрэглэхээр авах, хэрэглэж



ийм аяга нь Starbucks Corp, McDonald's Corp тэргүүтэй үйлдвэрлэгчдийн NextGen Cup Challenge хэмээх хоёр жилийн судалгааны хөтөлбөрийн үр дүн аж.

Зөвхөн энэ хоёр сүлжээ гэхэд л жилдээ хэдэн тэрбум ширхэг цаасан аяга хаядаг. Цаасан аяганы дийлэнх нь хуванцар дотортой учраас дахиварт ашиглах боломж бараг байдаггүй. NextGen групп мөн байгальд хаягдаж задрахаараа бордоо болдог, нэг удаагийн хэрэглээний аягыг Оклендэд турших төлөвлөгөөтэй байна.

Эх дэлхийдээ хөнөөл бага учруулах гэвэл материалын сонголт ач холбогдол бага. Учир нь цаас, хуудсан хөнгөн цагаан, хуванцрын алинаар нь ч хийсэн нэг удаагийн хэрэглээний аяга байгальд

дуусаад хураах цэгт өгөх болгондоо кодоор нь бүртгүүлнэ.

Харин Пало-Альтод Cup-Club стартапаас турших аяганы дизайныг Лондонд амьдардаг Сафия Куреши хэмээх архитектор 2015 онд гаргажээ. Аягыг хот доторх, тод шар өнгөөр тэмдэглэсэн хураах цэгүүдэд хялбархан хурааж болно.

Хуримтлагдсан аягыг автомашинаар зөөж цэвэрлэх цэгүүдэд хүргэх аж. Өөртөө RFID чиптэй ийм аягыг кофе шоп, хураах цэгүүд сканнердан бүртгэж авах аж. Шинэ системээ албан байгууллага, компаниудад борлуулах зорилготой Cup-Club дахин ашигладаг аяга нь лэндфилийн аргаар устгадаг хаягдлыг 40 хувиар бууруулж чадна хэмээн тайлбарлажээ. ■

“Роснефть”-д тогтоосон хориг газрын тосны үнийг тогтворжууллаа

Роб Вердонк, Шинжээч

АНУ-ын эрх баригчид ОХУ-ын тэргүүлэх олборлогчид хориг тавьсан нь коронавирусийн тархалтын улмаас эрэлт буурсан газрын тосны алдагдлыг нөхөж, үнэ тогтворжиход хүргэлээ.

Лхагва гарагт Азийн зах зээлд газрын тосны фьючерсийн үнэ 0.2 хувиар өсөв. Венесуэлийн Николас Мадуро, түүний

төрийн өмчийн газрын тосны компанитай хэлхээ холбоотой гэх шалтгаанаар ОХУ-ын “Роснефть”-ийн охин компани Rosneft Trading SA-д АНУ-ын засаг захиргаа хориг тавьсан юм.

Энэ шинэ хориг АНУ-ын Засгийн газраас Мадурогийн дэглэмд үзүүлэх шахалтаа өргөжүүлж буйн илрэл боллоо. “Роснефть” уг хориг арга хэмжээг үндэслэлгүй, хууль

бус гэж үзэж буйгаа мэдэгдэв. Коронавирусийн тархалтаас шалтгаалж энэ онд дэлхийн зах зээлд газрын тосны эрэлт багасаж, үнэ нь 15 орчим хувиар буураад байна.

Гуравдугаар сард нийлүүлэх West Texas Intermediate-ын үнэ Нью-Йоркийн таваарын биржид Сиднейн цагаар 10:08-д баррель нь таван центээр өсөж, 52.10 ам.доллар хүрлээ. Дөрөвдүгээр

сард нийлүүлэх Brent-ийн фьючерсийн үнэ Лондон дахь ICE Futures Europe биржид баррель нь найман центээр өсөж, 57.75 ам.доллар болсон юм. ■



ЦАГ ЗҮҮХ СОЁЛ ТАНЫГ ИЛЭРХИЙЛНЭ

Н.Сийлэн, ЗГМ сонин

З агварлаг эрчүүд бор гутлыг хар бүс, эрвээхэй зангиатай хослуулдаггүй гэдгийг аль эсвэл гэрийнхээ гадаа унтлагын хувцастай зогсох ёсгүйг мэднэ. Гэвч бугуйн цаг хэрэглэх соёлын тухай дийлэнх нь мэддэггүй. Эмэгтэй хүн төрөл бүрийн гоёл чимэглэл хэрэглэж, хувцаслалтаа тодотгох боломжтой байдаг бол эрчүүдийн хувьд хамгийн чухал гангараа нь бугуйн цаг. Бугуйн цагийг хэлбэр, хэмжээ, загвар зэргээс нь хамаарч, хувцаслалтдаа тохируулан сонгохын чухлыг дор танилцуулъя.



ХЯМДХАН ЦАГ ТАНЫ ИМИЖИЙГ ГУТААДАГ

Omega, Ulyse Nardin, IWC, Rolex, Baume Mercier, Arnold & Son, Hublot, Cartier, Zenith зэрэг дэлхийд нэр хүндтэй брэндүүд бий. Гэхдээ хүн бүр дээрх брэндээс сонголт хийх санхүүгийн чадавхгүй учир дундаас дээш болон дунд түвшний орлоготой иргэд төвлөрсөн Casio, Seiko, Tissot, Swatch, Citizen гэх мэт брэндээс сонголт хийх боломжтой.

ЦАГНЫХАА ХЭМЖЭЭГ ТОХИРУУЛ

Нэгэн үе том цаг тренд болж байсан боловч энэ сонголт хоцрогдож байна. Учир нь том цагийг бусдын анхаарлыг татах зорилгоор зүүдэг. Хэт том цаг таны бугуйг жижиг харагдуулахаас гадна өмссөн хувцасны тань зохицлыг алдагдуулдаг аж. Харин цагны оосрын хэмжээ гараа унжуулах үед хоёр см-аас илүү доошлохгүй байхаар бариу, гарт тань ором үлдээхгүй байхаар сул байх хэрэгтэй.

БУГУЙН ЦАГИЙГ ЗҮҮН ГАРТАА ЗҮҮДЭГ

Сүүлийн үеийн хувцаслалтын чиг хандлага цагийг аль ч гартаа зүүх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөх болсон. Та ажлаа хийх үедээ аль гараа илүү их ашигладгаа бодолцож үзээрэй. Гэхдээ зүүн гартаа зүүх нь тогтсон соёл гэдгийг мэдэхэд илүүдэхгүй. Ялангуяа бизнес уулзалтад очихдоо бугуйн цагийг зүүн гартаа зүүх нь чухал соёлд тооцогдоно. Судалгаагаар бизнес эрхлэгчид цагаа зүүн гартаа зүүхийг илүүд үздэг бол хөгжимчин, зураач зэрэг уран бүтээлч хүмүүс баруун гартаа зүүдэг нь тогтоогдсон аж. Мөн нөлөө бүхий байр суурьтай хүмүүс хүч чадлаа харуулахын тулд цагаа баруун гартаа зүүдэг бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин энэ жишгийг дагадаг.



Нөлөө бүхий байр суурьтай хүмүүс хүч чадлаа харуулахын тулд цагаа баруун гартаа зүүдэг бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин энэ жишгийг дагадаг. Гэхдээ зүүн гартаа зүүх нь тогтсон соёл гэдгийг битгий мартаарай.

ЦАГ ЗҮҮХЭД Ч ЦАГ ХУГАЦАА ХАМААТАЙ

Хэрвээ та бүх л өдрийн турш гадуур ажиллах бол аль болох цайвар өнгийн цаг зүүхийг эрхэмлээрэй. Бор болон хар өнгийн цагийг орой зүүхэд илүү тохиромжтой. Мөн үдийн хоолны үеэр бараан өнгийн цагнаас татгалзах нь зүйтэй. Чөлөөт хувцаслалтыг тод өнгийн цаг чимж өгдөг.

АЖЛЫН ЯРИЛЦЛАГАД ОРОХДОО НЭМЭЛТ ФУНКЦГҮЙ ЦАГ СОНГООРОЙ

Та ажлын ярилцлагад орох гэж байгаа бол нимгэн, дундаж хэмжээтэй, ямар нэгэн нэмэлт функцгүй, тэгш өнцөгт хэлбэртэй, хэт гял цал биш, бараан өнгийн суран оосортой цаг зүүх нь зохистой. Харин бизнес уулзалт, ямар нэг хэлэлцээр хийх гэж буй бол дугуй хэлбэртэй, нэмэлт функц бүхий, метал цаг зүүх нь таныг хүчирхэг харагдуулна.

ХАР ХОСЛОЛ ДЭЭР БОР ООСОРТОЙ ЦАГ ЗОХИМЖГҮЙ

Цагны тань өнгө энгэрийн зүүлт, гутлын гоёл, бөгж, бүс, чагтан товч зэрэгтэй хослох шаардлагатай. Жишээлбэл, шар метал зүүсэн бол алтлаг өнгөтэй цаг зүүх, хар хослол өмссөн бол бор оосортой цаг зүүхгүй байх зэрэг өнгөний зохицолд анхаараарай. Ямар ч төрлийн энгийн, хар нүүртэй цагийг эрвээхэй зангиатай хослуулан зүүж болдог.

ЦАГАА ОЙР ОЙРХОН ХАРАХ НЬ БҮДҮҮЛЭГ ҮЙЛДЭЛ

Хэдийгээр цаг эрчүүдийн хамгийн чухал гоёл мөн боловч ойр ойрхон харах нь таны нийгмийн харилцаанд сөргөөр нөлөөлдөг. Кино театрт эсвэл ресторанд утсаа оролдох нь бүдүүлэгт тооцогддогийн адил хэн нэгний өмнө цагаа дахин дахин шалгах нь харилцаж буй хүнээ үл хүндэтгэсэн, залхаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлдэг.

Эмэгтэйчүүдэд хэдэн зуун төрлийн гоёл чимэглэл байдаг бол эр хүнийг тодотгох, хамгийн чухал гоёл нь бугуйн цаг.



ЖЕЙМС БОНДЫГ ДУУРАЙХ ХЭРЭГГҮЙ

Усны хамгаалалттай цагийг усанд шумбах, орох үед л зүүдэг болохоос хэзээ ч хослол өмссөн үед зүүдэггүй байна. Яагаад гэвэл хэтэрхий том харагддаг. Жеймс Бонд тэгж зүүсэн байлаа ч энэ үйлдлийг дуурайх хэрэггүй. ■



Хаяад явсан эцгийгээ хуримдаа урих гэж үү



“Засгийн газрын мэдээ” сонин мэргэжлийн сэтгэлзүйчтэй хамтран бэлтгэдэг ээлжит зөвлөгөөгөө хүргэж байна. Энэ удаа “Улаанбаатар Эрдэм” их сургуулийн сэтгэл судлалын багш, сэтгэлзүйч Б.Батцэцэг уншигчдын асуултад хариуллаа. Хэрэв танд сэтгэл зүйн тулгамдсан асуудал байвал манай сонинд хаяглан ирүүлээрэй.

Г.Санжааханд, ЗГМ сонин



НӨХРИЙН МААНЬ ХҮҮХДИЙГ ТӨРҮҮЛСНИЙГ МЭДЛЭЭ

-Би жирэмсэн болоод төрөх хүртлээ нөхрөөсөө тусдаа байсан юм. Тэр хугацаанд өөр эмэгтэйтэй учир ургуулсныг нь мэдсэн ч уучилсан. Гэтэл тэр эмэгтэй нөхрийн маань хүүхдийг төрүүлснийг саяхан мэдлээ. Цаашид би яах ёстой вэ?

-Гэр бүлийн хосууд тусдаа байна гэдэг байж боломгүй зүйл. Яагаад гэвэл, хосууд гэр бүл болсон л бол хамт байж, бие биеэ түшиж, хайрлаж хайрлуулснаар хосын харилцаа бат бөх байх сууриа олдог. Ийм харилцаагаа алдагдуулснаас болж асуудал хүндэрсэн байна. Тиймээс одоо нөхөртэйгөө сайн ярилцаад үзэх хэрэгтэй. Хэрвээ таныг ойлгохгүй, хүлээн зөвшөөрөхгүй бол хэсэг хугацаанд орхихыг зөвлөж байна. Таны сэтгэл санаа хэцүү байсан ч тэвчиж, аль болох өөдрөг байж, өөр зүйлд сатаарч бие сэтгэлээ түр зуур чөлөөлөх хэрэгтэй.

10 ЖИЛ ХҮЛЭЭСЭН БҮСГҮЙДЭЭ

СЭТГЭЛЭЭ ИЛЧИЛТЭЛ ЗӨВШӨӨРСӨНГҮЙ

-Би 25 настай, эрэгтэй. Саяхан арван жилийн турш харж явсан бүсгүйдээ сэтгэлээ илчилсэн юм. Гэтэл “эрэгтэй хүмүүс бүгд адил, эмэгтэй хүнийг ашиглаад хаядаг” гээд зөвшөөрсөнгүй. Өөрийнхөө чин сэтгэлийг яаж ойлгуулах вэ?

-Та ийм хариулт авлаа гээд шантарч, сэтгэл санаагаар унах хэрэггүй. Хүн бүр адилгүй шүү дээ. Харилцаж буй хүнээ татах хамгийн шилдэг сэтгэл зүйн арга бол тухайн хүнийхээ сонирхдог, дуртай зүйлийг мэдэж, тэр зүйл дээр нь тулгуурлан яриагаа өрнүүлэх юм. Та эхлээд сэтгэл зүйг нь дасгаж байгаад хүндэтгэлтэйгээр дахин санал тавих хэрэгтэй. Ингэхдээ сайхан цэцэг өгөх, эсвэл дуртай зүйлийг нь мэдсэн бол бэлэглэж саналаа хэлбэл хүлээн авах нь гарцаагүй. Ямар ч хүн дуртай зүйлийг нь ярьж, түүний давуу талуудыг нь хэлж магтахад дургүй байдаггүй.

ТОГЛООМООС БОЛООД ХҮҮХДЭЭ ОР РУУ ШИДСЭН

-Нөхөр маань утсаар тоглоод хүүхдүүдээ тоохоо байсан. Хоол хийж байхад хүүхэд уйлахаар нь өвөр дээр нь аваачаад өгтөл “хожигдчихлоо” гэж уурлаад ор руу шидчихсэн. Би яахаа мэдэхгүй байна. Надад туслаач?

-Нөхөр тань өөрийгөө хэт их завтай байлгаж, ямар нэгэн асуудалд санаа зовнидоггүй

байсан тул анхаарлаа тухайн тоглоомд хандуулах болжээ. Чөлөөт цаг ихтэй болохоор тоглоом тоглох давтамж нь өдрөөс өдөрт ихсэж, ийм байдалд хүргэжээ. Өөрөөр хэлбэл, тоглоомдоо оюун санаагаа төвлөрүүлж, өөрийгөө болон орчноо хянах чадваргүй болсон гэсэн үг. Ийм хүнд түвшинд хүний сэтгэц буюу ухамсар шилжсэн нөхцөлд бага багаар ойлгуулж, аль болох тоглоом тоглох цагийг нь багасгах арга хэмжээ авах хэрэгтэй. Бүр болохгүй бол мэргэжлийн хүнд хандаж асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх нь нэн чухал.

ЭЭЖ МААНЬ ЗӨВХӨН НАДАД МУУХАЙ ААШ ГАРГАДАГ



-Ээж маань надад муухай ааш гаргаад, ах дүү хоёрт их сайн ханддаг. Тэр хоёр уурыг нь хүргэх зүйл хийсэн ч намайг хамааруулж загнадаг. Ингэхдээ зөвхөн над руу уурлаж байсан бол ахыг хараад юу ч болоогүй мэт инээдэг. Би яах учраа олохгүй байна?

-Та айлын дундах хүүхэд учир бусадтай өөрийгөө харьцуулах, жиших талаа сэтгэл зүйн хувьд



илүүд тавьж байна. Мөн айлын дундах хүүхдүүд асуудлыг бие даан шийдвэрлэх чадвар сайн байдаг учраас ээж нь зөвхөн танд итгэл хүлээлгэн санаа зовохгүй байгаа юм. Харин ах, дүү хоёр нь арай бие даах, асуудлыг шийдэх чадвар сул учраас магтаалын үг хэрэглэж, чадвар эзэмшүүлэх гээд ийн аашилж байгаа юм. Тэгэхээр үүнийг эмзэг хүлээж авалгүй, аль болох буруу бодож байгаа зүйлээ мартаж, ээжтэйгээ сайхан яриа өрнүүлээрэй. Ямар ч эх хүн үр хүүхдээ ялган хайрлаж, харьцдаггүй юм шүү.



өмөг түшиг, хүндэлж дээдэлж явах хүн бол яах аргагүй эцэг хүн байдаг. Амьдралын нөхцөл байдлаас үүссэн энэ асуудлаас болж аавдаа гомдож байгаа ч тэвчээртэй, ухаантай хандаж аавыгаа хүндэтгэлтэйгээр урих хэрэгтэй. Үр нь болж өдий хүртэл явнаа харуулж, ухааруулах хэрэгтэй шүү дээ. Хүн алдаж болно, гэхдээ охин үрээ хараад сэтгэл нь уярач, алдсан алдаагаа улам их ойлгож, таныг маш их хайрлах болно. Тиймээс жаахан сэтгэл санаагаа өөдрөг байлгаж, тэвчээртэй бөгөөд хүндэтгэлтэй хандаарай. ■

ХАЯАД ЯВСАН ААВЫГАА ХУРИМДАА УРЬ ГЭСЭН

-Би удахгүй хуримаа хийнэ. Гэтэл хаяад явсан аавыгаа урь гэсэн. Намайг 12 настай байхад аав минь хаяад явсан юм. Муухайгаар хэлэхэд, миний хувьд үхсэнээс өөрцгүй хүн. Ингэж бодож өдийг хүрчихээд урих хэрэгтэй гэж үү?

-Тухайн айлын өрхийн тэргүүн

ЗӨВЛӨГӨӨ

Охинтой аавууд урт насалж, стресс бухимдалд бага өртдөг

Охидууд эцэг, эхдээ аз жаргал дагуулан авчирдаг төдийгүй аавдаа урт удаан амьдрал бэлэглэдэг гэдэг. Нэг охин төрөхөд аавын амьдрах хоног 74 долоо хоног уртасдаг аж. Судалгаанаас үзэхэд охинтой аавууд бусад аавтай харьцуулахад илүү удаан амьдарч, төрөл бүрийн өвчнөөс хол байдаг. Хүүхэдтэй болох нь эцгийн эрүүл мэнд, бие махбодод хэрхэн нөлөөлдөг талаар төдийлөн сайн мэддэггүй тул гүн гүнзгий ухах зорилгоор Ягеллонский их сургуулийн судлаачдын хийсэн судалгааг Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сувилагч М.Буянхшиг танилцуулж байна. Эрэгтэй, эмэгтэй хүүхэдтэй аавуудыг хоёр бүлэгт хувааж, тэдний биеийн болон сэтгэхүйн эрүүл мэндийг шинжилж үзсэн аж. Судалгаагаар охинтой аавууд илүү удаан

амьдарч, стресс бухимдлаас хол байдаг төдийгүй эрүүл саруул, амар тайван амьдардаг болох нь тогтоогджээ. Охидтой аавууд илүү урт наслах хандлагатай байдаг бөгөөд охидын тоо олон байх тусам аавуудын амьдрах хугацаа уртасдаг байна.

Мөн өөр нэгэн судалгаанаас үзэхэд хүйс хамаарахгүй хүүхэдтэй болох нь эцэг, эхчүүдийн амьдрах хугацааг илүү уртасгадаг хэмээжээ. Тэд аав ээждээ аз жаргал бэлэглэж, ажлын стресс бухимдлыг нь тайлж, олон төрлийн өвчнөөс ангид байх боломжийг “бэлгэлдэг” аж. ■



ТӨМӨР ХУЛГАНА ЖИЛИЙН ҮР

Эх сурвалж: МБШТ ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН "БИЛГИЙН МЭЛМИЙ" СОНИН

Эрхшээсэн мэнгэний үр, засал

Аливаа хүмүүний төрсөн мэнгэ болон эрхшээсэн мэнгэ харилцан адилгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

-Нэг цагаан мэнгэ эрхшээвэл ариун бус болон үхэгсдийн үйл, бэрийн үйл, толгойн өвчин, өс хонзонгоос сэргийл. Далха тахиул, Алтангэрэл уншуул.

-Хоёр хар мэнгэ эрхшээвэл шөнө орой явах хийгээд хар өнгийн эдийг цээрлэ. Дээдэст зэмлэгдэх нигууртай. Хэл амнаас болгоомжил. Ширнэн, Цагаан шүхэрт уншуул.

-Гурван хөх мэнгэ эрхшээвэл газар ухах, чулуу ховхлох усны үйлийг тэвч. Ширнэн, Чогжүмүгсэл уншуул.

-Дөрвөн ногоон мэнгэ эрх-

шээвэл ургаа мод таслах, газар тариалан эрхлэх, найр хуримын идээ ундаа, хэрүүл тэмцэл аливаа ариун бусаас болгоомжил. Лүмбэнгарав уншуул.

-Таван шар мэнгэ эрхшээвэл ад зэтгэр, өвчин, тахалтай газраас болгоомжил. Жамбалцанжод, Цагаан шүхэрт уншуул.

-Зургаан цагаан мэнгэ эрх-

шээвэл бэрийн бохир идээ хийгээд ариун бус зүйл, үхээрийн бузар болон хэрүүл тэмцлээс болгоомжил. Сахиусны ганшиг уншуул.

-Долоон улаан мэнгэ эрхшээвэл уул хаданд авирах, улаан өнгийн эд авах, хануур төөнүүр хийлгэхийг цээрлэ. Хурим найр, улайны газар очихыг цээрлэ. Ширнэн, Чогжүмүнсэл уншуул.

-Найман цагаан мэнгэ эрхшээвэл өс хонзонгийн түйтгэр, ариун бус зүйлээс болгоомжил. Хүүрийн газар явахыг цээрлэ. Сахиусны ганшиг уншуул. Буяны саданг өргөн хүндэлбээс сайн.

-Есөн улаан мэнгэ эрхшээвэл улайг цээрлэ. Хүний хуучин эд, хувцас бүү ав. Оршуулгын газар очихдоо болгоомжил. Норжмаа сүн уншуул.

НЭГ. "ЖИЛ ОРОХ"

Огторгуйд урган гарч байгаа жил нь тухайн хүний төрсөн жилтэй давхцахыг "Жил орох" гэнэ.

- Эрэгтэй хүн жилээ угтдаг тул жил орохоос өмнө урдаас гүрэм сайн хийлгэ.
- Эмэгтэй хүн жилээ дагадаг тул жилийн хойно гүрэм сайн хийлгэ.
- Жил орогсод үхэгсэдийн үйл хийгээд хурим тэргүүтнийг цээрлэ.
- Бусад хүмүүс зохих засал гүрэм сайтар хийлгэх хэрэгтэй.

Нас	Төрсөн он	Төрсөн жил	Махбодь	Тайлбар	Заслын ном
13	2008	Шороон хулгана	хүү	Бие махбод хямрах жил	Нанжид, Лхамын ганшиг
25	1996	Гал хулгана	Нөхөр	Жаргал зовлон ээлжлэх жил	Доржнамжомын жавгүй, Цэнд-Аюуш
37	1984	Модон хулгана	Дайсан	Өвдөх хийгээд гарз болох жил	Улаан Юм, Цэнд, Лусын балин
49	1972	Усан хулгана	Эх	Хийморь доройтох жил	Нит, Жанцанзэмойбумчин, Пунцаг гүсүм
61	1960	Төмөр хулгана	Өөрийн жил бодитой	Шулмын хөнөөл болох жил	Ширнэн 1000 удаа айлтга
73	1948	Шороон хулгана	Хүү	Бие махбод хямрах жил	Нанжид, Лхамын ганшиг
85	1936	Гал хулгана	Нөхөр	Жаргал зовлон ээлжлэх жил	Доржнамжомын жавгүй, Цэнд-Аюуш
97	1924	Модон хулгана	Дайсан	Өвдөх хийгээд гарз болох жил	Улаан Юм, Цэнд, Лусын балин

ХОЁР. ДҮНСЭР БУЮУ "ИХ ХАРШ" ЖИЛ.

Өөрийн төрсөн жилээс тоолоод 7 дахь жил нь "Их харш" жил болно.

- **ХУЛГАНА, МОРЬ** хоорондоо харш
- Үхэр, хонь хоорондоо харш
- Бич, бар хоорондоо харш
- Туулай, тахиа хоорондоо харш
- Луу, нохой хоорондоо харш
- Могой, гахай хоорондоо харш

Энэ жил огторгуйд урган гарч буй жил нь "Төмөр хулгана" жил тул **Морь** жилтэнүүдийн хувьд "ИХ ХАРШ" жил болно. Иймээс харш жилийн засал хийлгэх нь чухал юм. Харш жил нь **7, 19, 31, 43, 55, 67, 79, 91** насанд тохионо.

Төрсөн он	Төрсөн жил	Билгийн нас	Анхаарах зүйлс	Заслын ном
2014	Модон морь	7	Аливаа санасан ажилд саад гарах нигууртай	Сундуй, Жанаггадог, Жанцанзэмойбумчин, Гомбо тахиул. Сахиусны ганс уншуул.
2002	Усан морь	19		
1990	Төмөр морь	31		
1978	Шороон морь	43		
1966	Гал морь	55		
1954	Модон морь	67		
1942	Усан морь	79		
1930	Төмөр морь	91		

ГУРАВ. ИВЭЭЛ ЖИЛ.

Ивээл жил нь 12 жил гурав гурваараа буюу төрсөн жилээс тоолоод 5, 9 дэх жил дээр таарч байгаа жилүүдийг ивээл жил гэнэ.

- **ХУЛГАНА, ЛУУ, БИЧ** ивээл жилүүд
- Үхэр, могой, тахиа ивээл жилүүд
- Нохой, бар, морь ивээл жилүүд
- Туулай, хонь, гахай ивээл жилүүд болно.

Энэ жилийн тухайд огторгуйд урган гарч байгаа жил нь "Төмөр хулгана" жил тул **Луу, Бич** жилтнүүдэд ивээл жил гарна. Ивээл жил гарахад хийморь доройтох нас таарах тул засал хийлгэх учиртай. Хийморь доройтох нас нь **5, 9, 13, 17, 21, 25, 29, 33, 37, 41, 45** бөгөөд Хийморийн сан, Цагаан шүхэрт, Сахиусны ганс уншуулж, хийморийн дарцаг хийсгэ.

ДӨРӨВ. ШИШИД БУЮУ БАГА ХАРШ ЖИЛ

Шишид буюу бага харш нь огторгуйн жилээс дээш ба доош 4 дэх жилийг хэлнэ. **ХУЛГАНА** жил нь **ТУУЛАЙ, ТАХИА** жилтэнүүдийн бага харш жил болно

Төрсөн он	Төрсөн жил	Билгийн нас	Анхаарах зүйлс	Заслын ном
2017	Улаагчин тахиа	4	Гэнтийн осол гадна барцад саад ихтэй.	Амин золиг гарга, Жадамба, Ногоон Дарь-Эх уншуул.
2011	Цагаагчин туулай	10		
2005	Хөхөгчин тахиа	16		
1999	Шарагчин туулай	22		
1993	Харагчин тахиа	28		
1987	Улаагчин туулай	34		
1981	Цагаагчин тахиа	40		
1975	Хөрөгчин туулай	46		
1969	Шарагчин тахиа	52		
1963	Харагчин туулай	58		
1957	Улаагчин тахиа	64		
1951	Цагаагчин туулай	70		
1945	Хөхөгчин тахиа	76		
1939	Шарагчин туулай	82		
1933	Харагчин тахиа	88		
1927	Улаагчин туулай	94		

ТАВ. ЛОГАР БУЮУ ЦАГААН ЖИЛ

Логар буюу цагаан жил нь өвөр хоорондоо үл тохирох хоёр жилийг ийн нэрлэнэ.

- Үхэр, бар хоёр тэмцэлдэнэ.
- Нохой, гахай хэрэлдэнэ.
- Морины туурайг тахиа тоншино.
- Луу, могой хоёр ороолдоно.
- Хонины толгойг бич хуулна.
- **ХУЛГАНЫГ ТУУЛАЙ** хөөх мэт хоорондоо үл тохирох хэмээн үздэг. Энэ "Хулгана" жилд "Туулай" жилтнүүдэд логар буюу цагаан жилийн засалтай.

Төрсөн он	Төрсөн жил	Билгийн нас	Анхаарах зүйлс	Заслын ном
2011	Цагаагчин туулай	10	Сэтгэл шаналах шарх гарах гэм буй.	Маналын чоги, уншуулж сахиус тахиул.
1999	Шарагчин туулай	22		
1987	Улаагчин туулай	34		
1975	Хөхөгчин туулай	46		
1963	Харагчин туулай	58		
1951	Цагаагчин туулай	70		
1939	Шарагчин туулай	82		
1927	Улаагчин туулай	94		
1915	Хөхөгчин туулай	106		

ЗУРГАА. МЭНГЭ ГОЛЛОХ

Хүний төрсөн жилийн мэнгэ есөн жил тутамд дахин давтагддаг. Энэхүү давтал буюу төрсөн жилийн мэнгэ огторгуйд дахин ургахыг мэнгэ голлох гэнэ. Хүний мэнгэ билгийн насаар **1, 10, 19, 28, 37, 46, 55, 64, 73, 82, 91** насанд есөн жилийн давталтаар голлож ирдэг. Хүний бие эхээс төрмөгц байгалийн цоо шинэ нөлөөлөлд орж дасдаг. Харин есөн жилийн дараа тэр орчин дахин давтагдахад хүний хувь заяа, ааш авир, зан төрх, бие бялдарт зохих нөлөө үзүүлдэг учир муу нөлөөлөл болон гай барцадыг зайлуулах учиртай. Үүнийг номын ёсонд мэнгэний засал гэнэ. Энэ жил найман цагаан мэнгэ эрхшээсэн "Төмөр хулгана" жил тул Долоон улаан мэнгэтэй хүмүүсийн мэнгэ голлоно. Иймээс мэнгэний засал хийлгэх ёстой.

Анхаарах зүйлс: Долоон улаан мэнгэ голлоход лусын хорлолоос болгоомжилж гүрэм засал хийлгэх. **Заслын ном:** Жанаггадог, Нанжид, Доржнамжим уншуулж бурхан сахиусаа тахиул.



SKY GARDEN

Дэлхийн барилга, архитектурын салбарт вертикал буюу босоо чиглэлд хөгжүүлсэн ногоон байгууламжийг Sky Garden хэмээн нэрийддэг бөгөөд энэхүү шийдлийг төлөвлөлтөнд тусгаснаар өндөр түвшний барилгад байгалийн мэдрэмжийг бодитоор хүртэх боломжийг бүрдүүлсэн.

VERTICAL GARDEN • BOSCO



True Luxury
ЗӨВ ТАНСАГЛАЛ



Сэтгэлд нийцэх "Байршил"

Ногоон бүсийн үнэ цэнэтэй байршил, 180-360 градус харах өнцөгтэй.



Ирээдүйгээ хайрласан "Хүүхэд төвтэй төлөвлөлт"

Хүүхдийн эрүүл аюулгүй хөгжих орчин



Winter Garden

Дөрвөн улирлын цэцэрлэг 4-н улирлын ногоон байгууламж



Аюулгүй байдлыг бүрэн хангасан "Дугуйн гүүрэн гарц"

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй холбогдсон аюулгүй гарц



Рашаан түгээх системтэй

Дөрвөн улирлын турш гэртээ рашаанд орох боломж



Чанарын баталгааг амлах "Материалын сонголт"

Дэлхийн шилдэг чанартай материалаар брэнд орчинг цогцлоосон



Бүхнийг цогцлоосон "Sky Park Plaza"

Хүний бүх хэрэгцээг нэг дор цогцлоосон нэгдсэн үйлчилгээний төв



Газар доогуурх зам бүхий "Галерей"

Хотхоны бүх барилга болон үйлчилгээний төв газар доогуураа туннелээр холбогдсон

Sky Garden Residence...
Yet within, peace and calm prevails.



SKY | GARDEN | RESIDENCE



Борлуулалтын оффис | Sales Office
+976 771 55555

Борлуулалтын менежер | Sales manager
+976 8888 0835, 8888 0836, 8888 0837

skygarden.mn
info@skygarden.mn


Адал явдалд дурлагч М.БУМАА

✍ Н.Сийлэн, ЗГМ сонин

“Гоо сайхан” буландаа адал явдалд дурлагч, үзэсгэлэнт бүсгүй М.Бумааг онцолж байна. Түүний хобби нь аялах бөгөөд Зүүн өмнөд азийн ихэнх оронд очсон аж. Боловсролоо дээшлүүлэхээр Итали улсад суралцаж буй тэрбээр мэргэжлээрээ ажиллахын хажуугаар загварын салбарт хөл тавьж, дотуур хувцасны брэндийн нүүр царайгаар сонгогджээ.


- **Биеийн жин:** 50 кг
- **Биеийн өндөр:** 176 см
- **Биеийн харьцаа:** 90:60:87
- **Биеийн хамгийн дуртай хэсэг:** Цээж
- **Орд:** Загас
- **Төрсөн он, сар, өдөр:** 1998.03.07
- **Үсний өнгө:** Хар
- **Нүдний өнгө:** Хар
- **Төгссөн сургууль:** ШУТИС
- **Ажил:** “Венус иог”-ийн заал хариуцсан менежер
- **Мэргэжил:** Харилцааны менежмент
- **Идэх дуртай хоол:** Далайн хоол
- **Дуртай сүрчиг:** Gucci flora
- **Дуртай өнгө:** Хар, цагаан
- **Хобби:** Аялах, сэлэх, эдийн засгийн ном унших
- **Зорилго:** Итали улсад магистрт суралцах
- **Дуртай брэнд:** Kef lingerie
- **Баримталдаг зарчим:** Бусдад саад учруулахгүй байх
- **Нууц авъяас:** Реп үглэх
- **Багын хоч:** Бумбаарай
- **Үзэх дуртай кино:** Шиндлерийн бүртгэл
- **Хэлэх дуртай үг:** I dont give shit everyone
- **Өглөөг хэрхэн эхлүүлдэг вэ:** Дуу сонсож эхлүүлдэг
- **Утасны дэлгэцэн дээрх зураг:** “Never give up” гэсэн үг байдаг
- **Instagram хаяг:** Buma5555






PEN BOUTIQUE

2nd floor, Central tower, 2
Sukhbaatar square, khoroo 8,
Sukhbaatar district

 penboutiquemongolia

 penboutique.mn

 7000-9880



ҮНСЭЖ, ХАЦРАА НИЙЛҮҮЛЖ ОГТ БОЛОХГҮЙ

Уламжлалт баяраар аав, ээжтэйгээ золгохдоо зүүсэн амны хаалтаа бүү аваарай. Мөн бие, биеийнхээ гарт хүрэхгүй золгохыг хичээгээрэй.

Тухайлбал, алсаас мөргөж, мэндчилж, шуу зөрүүлж болох юм. Харин үнсэж, хацраа нийлүүлж огт болохгүй. Учир нь COVID-19 халдвар зөвхөн агаараар бус ахуйн замаар ч дамждаг. Мөн бага насны хүүхэдтэй бол гэрээсээ гаргахгүй байх хэрэгтэй.

ХӨӨРГӨӨР ВИРУС ДАМЖИХ ЭРСДЭЛТЭЙ

Хөөрөг зөрүүлж, мэнд мэдэх нь манай уламжлалт соёл. Гэхдээ шинэ төрлийн корона вирус хуурай гадаргуу дээр ч оршиж чаддаг тул хөөрөг, даалингаар халдвар дамжих өндөр эрсдэлтэй. Тиймээс өөрийнхөө болон, бусдын эрүүл мэндийн төлөө хөөрөг зөрүүлэхээс татгалзаарай. Хэрэв гарцаагүй нөхцөл байдал үүсвэл ариутгагч спирт, зориулалтын салфетикаар гар, гар утас, хөөрөг, түрийвч зэргээ тогтмол ариутгаарай. Ахмадуудад мөнгө барьж золгох нь мөн л халдварын эх үүсвэр болох тул дансаар нь шилжүүлэх аюулгүй шийдэл болно.

ЛИФТНИЙ ТОВЧЛУУРТ БҮҮ ХҮР

Коронавирус тархах хамгийн эрсдэлтэй газар бол орон сууц болон оффисын лифт болохыг Хятадын Эрүүл мэндийн хорооны тэргүүн Чун Наншань анхааруулсан байна. Тиймээс сар шинийн баяраас өмнө байр, орцныхоо цахилгаан шатыг ариутгаж, халдваргүйжүүлээрэй. Мөн лифтний товчлуурт гар хүрэхгүй байхыг хичээх хэрэгтэй бөгөөд бээлий өмсөж хэвшээрэй.

Цагаан сараар COVID-19 халдваргүй шинэлцгээе

Зочдод зориулсан зоог бүрт халбага, сэрээ, савх бэлтгээд, өөрийнхөө идэж буй халбагаар хоол, зуушинд хүрэхгүй байхыг сануулаарай

✍ О.Даваасүрэн, ЗГМ сонин

Коронавирусийн халдвар БНХАУ-ын ихэнх мужид болон дэлхийн олон оронд тархаж, үүний улмаас 2100 гаруй хүн амиа алдаад байна. **Уг вирус ийнхүү хурдацтай тархах болсон гол шалтгаан нь Хятадууд Цагаан сарын баяраа тэмдэглэн, бие биеийнхээрээ**

зочилж, нэг тавагнаас олуулаа хооллосонтой холбоотойг албаныхан мэдээлж буй. Тиймээс манай улс сар шинийн баяр хийхгүй байж, айл хэсэхгүй, гэр гэртээ тэмдэглэн, аймшигт вирусийн халдвараас сэргийлэх шийдвэр гаргасан. Гэхдээ өвөө, эмээ, аав, ээжтэйгээ золгох зайлшгүй шаардлагатай бол өөрийгөө болон хайртай хүмүүсээ халдварын эрсдэлээс сэргийлэх зөвлөгөөг хүргэе. ■

ГАДУУР ХУВЦАСТАЙ НЬ ГЭРТЭЭ ОРУУЛАХААС СЭРГИЙЛ

COVID-19 хуурай гадаргуу дээр хоёр өдөр, шингэн орчинд түүнээс ч удаан амьдардаг учир гадуур хувцас, малгай, бээлийгээр халдвар дамжих эрсдэлтэй. Тиймээс **хүн ирвэл гадуур хувцсыг нь тусгай өлгүүрт байрлуулах нь зохимжтой. Харин өлгүүр байршуулсан газраа тогтмол цэвэрлээрэй. Мөн гар ариутгагч, нэг удаагийн улавчийг гэрийнхээ үүдэнд тавьж, ирсэн зочдод улавч өмсөж, гараа ариутгахыг зөвлөөрэй.**

АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНДӨӨ ГАДНЫН ХҮН ОРУУЛАХ ХЭРЭГГҮЙ

Коронавирус өтгөн, хөлс, шүлс гэх мэт хүний биеэс ялгарч буй бүх шингэнээр халдварлаж байгаа. Тиймээс **ариун цэврийн өрөөний суултуур халдвар тараах эрсдэлтэй учир ОО-ын өрөөндөө гаднын хүн оруулахгүй байхыг хичээгээрэй. Мөн айлд зочлохдоо ариун цэврийн өрөөг нь ашиглахгүй байхыг зөвлөж байна. Харин гар ариутгагч биедээ авч яваад, тогтмол ашиглах хэрэгтэй.**

ӨӨРИЙН ХАЛБАГА, САВХААР ХООЛ ЗУУШИНД ХҮРЭХГҮЙ БАЙХ

БНХАУ-д халдвар их хэмжээгээр тархах болсон нэг шалтгаан нь зоог. Учир нь тэд баярын үеэр нэг тавагнаас олуулаа идэж, бие, биеийнхээ савх хүрсэн газраас хооллосон нь тогтоогдсон. Ийнхүү нэг халдвартай хүний халбага хүрсэн хачираас олон эрүүл хүн идэж, халдвар хурдацтай тархсан. Тиймээс **зочдод зориулсан зоог бүрт халбага, сэрээ, савх бэлтгээд, өөрийнхөө идэж буй халбагаар хоол, зуушинд хүрэхгүй байхыг сануулаарай. Мөн аяга, таваг, халбага, сэрээгээ ариутгалын бодис бүхий зориулалтын угаагчаар цэвэрлээрэй.**

ZGM DAILY

⊖ The State Special Commission decides to suspend all movements of automobiles, buses, and railway between Ulaanbaatar and 21 provinces from 08.00 am of February 23 to 08.00 am of February 27 during the Lunar New Year.

⊖ Top 20 index decreases 0.21 percent, to 19,176.16 points. MSE A Index drops 0.68 percent, to 9,406.12 points. MSE B index rises 0.21 percent, to 7,753.28 points. Market cap stands at MNT 2.75 trillion.

THIRD NEIGHBOR POLICY ON MONGOLIA-JAPAN RELATIONSHIP (2)

Japan is the fourth largest country that invests in Mongolia and the fifth largest foreign trade partner



✍ Bayarkhuu.D, Prof.

Please read the previous part from issue No.031

Mongolia-Japan relation is a classic example of the continuity and expansion of Mongolia's foreign policy, during all the presidency, the MPs and governments of our country. This is a page from the past 30 years of history.

Over the last two years, with a turning point in bilateral relations, the Government of Japan has announced a policy to support Mongolia's democracy and reforms in bilateral relations and internationally in 1991; the Prime Minister of Japan visited Mongolia for the first time in the year. Since then, cooperation between the two countries has been consistent.

Mongolia has set a goal of expanding relations and cooperation with Japan as one of its foreign policy priorities, and the Government of Mongolia had implemented it in its action programs. There was no ruling party or government to curtail relations with Japan. There are differences in domestic politics from the political parties, but foreign policy, in particular to the third neighbor, Japan, has continued to be inherited.

The Mongolia-Japan joint declaration on building a Partnership of Friendship and Cooperation for Peace and Development, first introduced in 1998 by the President of Mongolia, Bagabandi Natsag during his visit to Japan, stated the principle of developing bilateral relations in the framework of a comprehensive partnership for the 21st century. That concept came to effect, and the Part-




Image by Batsaikhan.S

nership moved forward, reaching a Strategic Partnership in 2010. The two countries are now establishing strategic partnership relations of the 21st century.

Mongolia-Japan relations are now expanding in all fields. For example, political talks are ongoing, mutual understanding is growing, and high and summit visits are being intensified. The following is a list of the most visited destinations of Mongolian side to Japan:

MONGOLIA HAS SET A GOAL OF EXPANDING RELATIONS AND COOPERATION WITH JAPAN AS ONE OF ITS FOREIGN POLICY PRIORITIES, AND THE GOVERNMENT OF MONGOLIA HAD IMPLEMENTED IT IN ITS ACTION PROGRAMS.

The President of Mongolia was invited to the enthronement ceremony of the emperor of Japan in 1991 and visited the country in 1998, 2003, 2007, 2010, 2014, and in 2015 participated in the Nikkei Newspaper International Forum, Asia's Future.

The Prime Minister of Mongolia visited Japan in 1992, 1994, 1997, 2001, 2006, 2009, 2012, 2013, 2015, 2016, 2018, and participated in the enthronement ceremony of the emperor of Japan in 2019.

The Speaker of the Parliament visited Japan in 1994, 1999, 2002, 2008, 2011, 2015, 2016, 2017 and participated in the international forum "Asian Future" of the Nikkei newspaper in 2019.


THE PRESIDENT OF MONGOLIA, BATTULGA KHALTMAA HAS NOT YET VISITED JAPAN AS OF THE BEGINNING OF 2020 SINCE HE WAS ELECTED IN 2017. HOWEVER, HE BEGAN THE PRACTICE OF CONDUCTING REGULAR BILATERAL MEETINGS WITH THE PRIME MINISTER OF JAPAN, ABE SINZO DURING THE EASTERN ECONOMIC FORUM.

From the Japanese side, the Prince of Japan Akishino visited in 2002, the Crown Prince of Japan in 2007. The Prime Minister of Japan visited the country in 1991, 1999, 2006, 2013, and 2015, and again in 2016 when he was invited to attend the XI ASEM Summit. Specifically, Mr. Abe Shinzo visited Mongolia three times as Prime Minister of Japan. The Chairman of the House of Councillors of Japan visited our country in 1992, and the Chairman of the House of Representatives in 2017. From the Japanese side, it may appear to be few visits at the parliament speaker level, but many visits have been made at the level of the Deputy Speaker of the Parliament, the Standing Committees Chairman, the Chairman of the Group and the Representatives of Parliament.


The President of Mongolia, Battulga Khaltmaa has not yet visited Japan as of the beginning of 2020 since he was elected in 2017. However, he began the practice of conducting regular bilateral meetings with the Prime Minister of Japan, Abe Sinzo during the Eastern Economic Forum, which takes place in Vladivostok,

COMMODITY MARKET


WTI Crude Oil (Nymex) (USD/bbl.)



Brent Crude (ICE) (USD/bbl.)



Gold Spot (USD/t oz.)



Source: BoM

Russia, on September 9, 2017.

The Mongolian-Japanese Foreign Ministry has been holding regular policy consultations since 1996. The Mongolia-Japan-U.S trilateral meeting is also being held regularly. The sides discuss regional issues, strengthening cooperation between Mongolia, Japan, and the United States, as well as regional issues during the meeting. The latest meeting, which took place in January 2020 in Washington, D.C. has reaffirmed the commitment of three sides to strengthen Mongolia's relations with Japan in the context of Mongolia's third neighbor policy, as well as the parties' views on the Indo-Pacific region. Mongolia, Japan, and the United States present their proposals on regional development, including the Indo-Pacific perspective, and work together to build a prosperous and peace-loving region with the sovereign and democratic nations. The three sides appreciated the fact that the United States has become Mongolia's strategic partner in 2019, as well as Japan, and expressed its intention to further strengthen the strategic partnership. The three sides are working to strengthen Mongolia's business environment, especially its capacity to attract investment from Japan and deepen its economic partnerships by increasing its cooperation in energy, e-economics, and cybersecurity.

I would acknowledge that Mongolia-Japan economic cooperation has left behind active political ties.

JAPANESE PRIVATE COMPANIES HAVE BEEN OPENLY EXPRESSING THEIR ASPIRATION TO PARTNER WITH MONGOLIA. WE MUST SEE THIS AS A GREAT OPPORTUNITY. JAPAN'S MITSUI, SUMITOMO, MITSUBISHI, AND ITOCHU HAVE PROPOSED INVESTING IN MAJOR MINING FIELDS, SUCH AS OYU TOLGOI AND TAVAN TOLGOI. JAPAN'S SUPERSTAR, WORLD-CLASS ENTREPRENEUR AND CHAIRMAN OF SOFTBANK GROUP, MASAYOSHI SON HAS SET UP A RENEWABLE ENERGY COMPANY WITH MONGOLIAN COMPANY NEWCOM.

Mongolia leads other countries with Japanese loans and grants per capita. Japan is the fourth largest country that invests in Mongolia and the fifth largest foreign trade partner.

Mongolia had officially started to receive Japan's Official Development Assistance (ODA) in 1987. The governments of the two countries negotiated and set priorities for de-

velopment assistance in Mongolia in 1997, and in 2004 the Government of Japan developed a ODA program to Mongolia. Then, in 2011, the program was updated. We have the following priority areas in our country: 1. to support sustainable mining development and strengthen governance; 2. reduce poverty and improve living standards; 3. Improve the infrastructure of Ulaanbaatar city.

However, both sides expect further mutually beneficial co-operation over the next ten decades. In other words, if Mongolia's economy boom for some years as a result of its natural resource exports, and if it continues to grow, it will reduce Japan's grants and increase co-operation and investment.

Japanese private companies have been openly expressing their aspiration to partner with Mongolia. We must see this as a great opportunity. Japan's Mitsui, Sumitomo, Mitsubishi, and Itochu have proposed investing in major mining fields, such as Oyu Tolgoi and Tavan Tolgoi. Japan's superstar, world-class entrepreneur and chairman of SoftBank Group, Masayoshi Son has set up a renewable energy company with Mongo-

lian company Newcom. Masayoshi Son is successful in the field of information technology, according to Forbes Magazine, ranked second in Japan and 127 in the world. The Japanese expressed interest in implementing satellite projects, supplying railways, railway steel and steel wheels to Mongolia.

One common problem is that we, as Mongolians, need to work on the use of the Tavan Tolgoi coal deposit, as well as the making involvement, and strengthening of Japanese companies in major infrastructure and energy projects.

Mongolia had officially started to receive Japan's Official Development Assistance (ODA) in 1987. The governments of the two countries negotiated and set priorities for development assistance in Mongolia in 1997, and in 2004 the Government of Japan developed a ODA program to Mongolia. Then, in 2011, the program was updated.

Japan, the U.S, and India with "strategic partnerships" are our third neighbors. It is Mongolian interest that Mongolia's foreign relations eventually equate with the Eternal Neighbor, including Russia and China, into an "equilateral" triangle. The side of third neighbors to be larger and closer is one of Mongolia's foreign policy goals.

I would like the Government of Mongolia to provide this interest and promptly encourage Japan to invest in large mining areas of Mongolia. ■

ZGM: HIGHLIGHTS

■ POLITICS

The State Special Commission decides to suspend all movements of automobiles, buses, and railway between Ulaanbaatar and 21 provinces from 08.00 am of February 23 to 08.00 am of February 27 during the Lunar New Year.

Chairman of the City Council of Ulaanbaatar meets with Ambassador of the Republic of Poland to Mongolia, Kshyshtof Boiko on February 19. This year marks the 70th anniversary of the establishment of diplomatic relations between Poland and Mongolia. On the occasion of the anniversary, a series of activities are intended to be organized in March and April.

■ ECONOMY

Top 20 index decreases 0.21 percent, to 19,176.16 points. MSE A Index drops 0.68 percent, to 9,406.12 points. MSE B index rises 0.21 percent, to 7,753.28 points. Market cap stands at MNT 2.75 trillion.

■ SOCIETY

SSC decides to continue coal and crude oil export regularly from March 2, 2020. Following the coronavirus confirmation near 62 miles from Gashuunshukhait port, Bichigt, Bulgan, Shiveekhuren, and Gashuunshukhait ports were closed from February to March 2, 2020.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.02.21

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:

"Принтерийн хор, Компьютерийн дагалдах хэрэгсэл, сэлбэг" нийлүүлэх тендер нь дараах 2 багцтай.

Багц 1 Принтерийн хор
Багц 2 Компьютерийн дагалдах хэрэгсэл, сэлбэг
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:
МИАТ/202002027

МИАТ ХК эрх бүхий тендэрт оролцогчдоос: "Принтерийн хор, Компьютерийн дагалдах хэрэгсэл, сэлбэг" нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул <http://www.tender.gov.mn> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендэрт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 төгрөг, төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил 2018, 2019 онуудын аль нэгэн жилд доод тал нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас доошгүй хэмжээний принтерийн хор

болон компьютерийн дагалдах хэрэгсэл сэлбэг материалын худалдах, худалдан авах гэрээ байгуулж үндсэн нийлүүлэгчээр ажилласан байх ба гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ.

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж борлуулалтын орлого нь төсөвт өртгийн дүнгээс 100 хувиас багагүй /2018, 2019он/

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 60 хувиас багагүй байна

Тендерийн хамт
Багц 1-т **1,182,992** төгрөг
Багц 2-т **844,400** төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх тус тус тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 09.00 цаг** –аас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 09.10 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй Дотоодны давуу эрх тооцно.
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа, МИАТ ТӨХК-ийн төв байр
Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө, www.tender.gov.mn
Утас: 70049860, Факс: 70049919

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.02.21

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: "Таблет" нийлүүлэх тендер.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:
МИАТ/202002164

МИАТ ХК эрх бүхий тендэрт оролцогчдоос: "Таблет" нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул <http://www.tender.gov.mn> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендэрт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 төгрөг, төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил 2018, 2019 онуудад доод тал нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас доошгүй хэмжээний Компьютер, мэдээлэл холбооны тоног төхөөрөмжийн худалдах, худалдан авах гэрээ байгуулж үндсэн нийлүүлэгчээр

ажилласан байх ба гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ.

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж борлуулалтын орлого нь төсөвт өртгийн дүнгээс 100 хувиас багагүй /2018, 2019он/

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй байна

Тендерийн хамт **2,103,750.00** төгрөгийн үнийн дүнтэй тэнцэх тус тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 10.00 цаг** –аас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 10.10 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа, МИАТ ТӨХК-ийн төв байр
Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө, www.tender.gov.mn
Утас: 70049860, Факс: 70049919

Сарьсан багваахай хүн төрөлхтний дайсан болжээ

2003 оны SARS-ын вирусийг сарьсан багваахайнаас үүсэлтэй гэж үздэг

✎ Пэр Кудо /Svenska Dagbladet/

Нисдэг хулгана хэмээх энэ амьтныг Эбола, халуун ханиад, Ойрх Дорнодын амьсгалын замын синдром гэх мэт зүсэн зүйлийн халдварт буруутгаж байсан бол одоо шинэ коронавирусийн буруутан боллоо. Сүүн тэжээлтний төрөлд багтдаг сарьсан багваахай үхлийн аюултай олон вирусийг тараадаг тул “хүн төрөлхтний гол дайсан” хэмээх нь бий. Үнэхээр тийм гэж үү. Сарьсан багваахай судлаач, Шведийн эрдэмтэн Юхан Эклеф Уханийн халдвар тарж эхлэхэд “Одоо ийм яриа эхэлнэ дээ” гэж бодож байжээ.

Үүнээс ердөө хоёр хоногийн дараа шинэ коронавируст сарьсан багваахайг буруутгасан өгүүлүүд шил дараалан гарч иржээ. Генетикийн шинжилгээнээс үзэхэд коронавирус үнэхээр уг амьтнаас хүнд дамжсан

болохыг илрүүлсэн. Эхэндээ могойг сэжиглэж байсан ч хуучин буруутны нэр шинээр дурдагдаж эхлэв. Британийн Sun сонинд “Нисдэг зандалчин. Ийм учраас сарьсан багваахай хүн төрөлхтний гол дайсан, түүхэнд хамгийн муу өвчнөөр хэдэн сая хүнийг хөнөөсөн буруутан” хэмээн бичсэн байна.

Энэ сүүн тэжээлтэн аюултай вирус дамжуулдаг хэд хэдэн шалтгаан бий. Хувьслын үүднээс авч үзвэл энэ амьтан маш эртнийх. **Сарьсан багваахай 65 сая жилийн өмнө төгссөн үлэг гүрвэлийн эринд ч амьдарч байжээ. Ийм урт түүхийн явцад олон тооны вирус хуримтлуулсан нь гарцаагүй.** Дэлхий дээр олон төрлийн вирус хүн, амьтан, ургамал болон бусад организм дотор оршин байдаг. Гэхдээ сарьсан багваахай шиг вирусгүй зохицож чаддаг амьтан ховор. Орчин үед түүнээс хүнд халдсан вирус үхлийн аюул тарьдаг ч өөрт нь хөнөөлгүй юм.

Упсалийн их сургуулийн вирусолог Аке Лундквист шинэ вирусийг сарьсан багваахайд удаан хадгалагдсан байж магадгүй хэмээн таамаглажээ. Тэрээр “Вирус өөр организмд шилжихийн өмнө хэдэн мянга, сая жилээр ч байгалийн эзэндээ оршиж болно. Шилжилт гол төлөв хүний үйлдлээр хийгддэг” гэсэн юм. Сарьсан багваахай халдварыг яагаад ийм түргэн тараадаг өөр шалтгаан бас бий. Энэ амьтан сүүн тэжээлтнээс ганцаараа нисдэг учир өргөн уудам нутагт хурдан тархан оршдог. Үүнээс гадна хүнтэй маш ойр амьдардаг.

Африкт болон Хятад, Вьетнам зэрэг оронд сарьсан багваахайг хүнсэнд хэрэглэдэг учир халдвар дамжуулж болзошгүй. 2003 онд дэгдсэн SARS-ын вирус сарьсан багваахайнаас үүсэлтэй гэж үздэг. Энэ амьтныг эрт дээр үеэс цус сорогч, муу шид агуулагч, харанхуйн үүсгэл мэтээр цоллож ирсэн. Саяхан Хятадын блогчин Ван Мэньюн сарьсан багваахайн

БРИТАНИЙН SUN СОНИНД “НИСДЭГ ЗАНДАЛЧИН. ИЙМ УЧРААС САРЬСАН БАГВААХАЙ ХҮН ТӨРӨЛХТНИЙ ГОЛ ДАЙСАН, ТҮҮХЭНД ХАМГИЙН МУУ ӨВЧНӨӨР ХЭДЭН САЯ ХҮНИЙГ ХӨНӨӨСӨН БУРУУТАН” ХЭМЭЭН БИЧСЭН БАЙНА.

багваахай тоймгүй олон хүний амийг авч байгаа атал бид яагаад энэ амьтныг тэвчих ёстой гэж” хэмээн асуужээ. Гэвч үнэндээ шинэ коронавирус болон бусад аюулт өвчнийг тараадаг гол буруутан нь хүн өөрөө юм. Хэрэв энэ амьтныг Уханьд хаалттай орчинд хашаагүй бол, зарим газар түүхийгээр нь идээгүй бол, судалгааны зорилгоор бариагүй бол олон вирусийн халдвараас зайлсхийх байлаа.

Шведийн Мал эмнэлгийн хүрээлэнгийн дэд захирал Лийз Берндтсон “Зүүн Азиас ханиадны бараг бүх нян тархдаг нь тохиолдлын хэрэг бус. Тэнд вирус амьтнаас хүнд онцгүй нөхцөл байдалд халдварладаг” хэмээн тайлбарлажээ. Сүүлийн коронавирусийн халдвараас авах гол сургамж нь хэрэв амьтнаас хүнд вирус дамжиж байгаа бол хүн өөрөө олонх тохиолдолд буруутай. Ирээдүйд сарьсан багваахайг амар тайван орхих хэрэгтэй гэжээ. ■

шөл ууж буй бичлэгээ онлайнд тавьсан боловч эрс эсэргүүцэлтэй тулгарч, арилгахад хүрчээ. “Энэ амьтан нэг орой 3000 орчим шавжаар хооллодог тул хүний биед тустай байж болох юм” хэмээн доктор Эклеф бичжээ. Sun сонины өгүүлэлд “Сарьсан

Коронавирусийн эсрэг эмийг Албидол гэж нэрлэлээ

Хятадын Эрүүл мэндийн яамны мэдэгдэлд коронавирусийн эсрэг хэрэглэх эмийг Албидол хэмээн цохон заажээ. Уг эм COVID-19 вирусийн халдварыг эмчлэх зургаа дахь хувилбарт багтаж, хлорохинфосфат, Рибавирин, интерферон, лопинавир, ритонавир зэрэг эмүүдтэй хавсран хэрэглэж болохыг зөвлөсөн байна. Өмнө нь Албидолыг бусад бэлдмэлтэй хослуулан хэрэглэх эмчилгээний төлөвлөгөөнд оруулж байсан юм. **Хятадын эмч нар уг эмийг вирусийн эсрэг өндөр үзүүлэлттэй хэмээн мэдээлжээ.**

Гэхдээ үүнийг ОХУ-д худалддаг Арбидол гэдэг эмтэй андуурч болохгүй аж. Мягмар гарагт Хятадын Өвчлөлийг хянах ба сэргийлэх төвөөс COVID-19 вирусийн талаар одоо



байгаа хамгийн том судалгааны дүнгээ танилцуулсан юм. Мэргэжилтнүүд халдвар авсан 72.3 мянган өвчтөний түүхийг судлаад дундаж нас нь 30-69

байгааг тогтоожээ. Тэдний олонх нь Уханьтай холбоотой байна. Уг вирус 20 улсад тархаж, 2100 гаруй хүн нас бараад байна. ■

Өрнөдийн хоол нэмж идэх хүсэл төрүүлдэг

Эрдэмтдийн судалгаагаар өрнөдийн маягийн хоол буюу чихэрлэг, тослог хүнс тархины гиппокамп хэмээх хэсгийг гэмтээж, улмаар хоол идэхэд тавих хяналтаа алдахад хүргэдэг аж. Royal Society Open Science сэтгүүлд нийтлэгдсэн Австралийн Маккуори их сургуулийн судалгааны тайланд бичсэнээс үзвэл эрдэмтэд сахар ба өөх тосны өндөр агууламж хүний тархинд хэрхэн нөлөөлдгийг туршсан байна. Туршилтад өвчин хуучгүй, эрүүл хооллохыг хичээдэг 20-30 насны 110 сайн дурын залуу оролцов.

Тэднийг хоёр бүлэгт хувааж, эхний бүлэг нь энгийн хоол идэх бол хоёр дахь

бүлэгт түргэн хоол, амттан өгчээ. Туршилтын эхний ба сүүлийн өдөр оролцогсдоос ой санамжийн тест авч, сахар ихтэй хоол идэх дуршлыг үнэлсэн байна. **Хоёр дахь бүлгийн хүмүүс өглөө цагталан байсан ч түргэн хоол, амттан нэмж идэхийг хүсэж байжээ.** Эндээс үзэхэд сахар, өөх тосны агууламж ихтэй хоол идэх нь эргэх холбоо үүсгэж, байнга хэтрүүлж идэх, өөхлөх болон бусад эмгэгт хүргэж болохыг анхааруулжээ. ■



ЭНЭ ӨДРИЙН ЗУРХАЙ

Охины ордынхны гэрээ хэлэлцээр амжилттай болно



Хонь /III.21-IV.19/

Та өөрийн хэзээ ч бүтэхгүй тэнэг мөрөөдлөөсөө болж дэргэдэх хүнээ гомдоож, өөрөө сэтгэлийн гүн хямралд өртөнө. Үүссэн нөхцөл байдлаас гарахын тулд дотор буглаж байгаа бүхий л зүйлээ хэн нэгэнд дэлгэн хуваалцаарай. Хайр дурлалдаа умбаад сүүлийн өдрүүдэд өөр бусдыг анхаарах завгүй яваа бусгүйчүүдэд бага зэргийн үл ойлголцол үүсэж, түр салж болзошгүй.



Мэлхий /VI.22-VII.22/

Ажлын сүүлийн өдөр хэдий ч таны эрч хүч буураагүй, урам зориг дүүрэн байна. Өнөөдөр та нисэхэд ч бэлэн сэтгэл санаа сайхан, хөнгөн байна. Ажлын уулзалт зохион байгуулах бол санаа зовох зүйлгүй бүх зүйл бодсоноор амжилттай дуусах болно. Гэхдээ хамтрагчдынхаа өмнөөс томоохон шийдвэр гаргахгүй байхыг зөвлөж байна. Гэр бүлд өөрийн өөрийн үзэл бодол ноёрхон.



Жинлүүр /IX.23-X.22/

Энэ өдөр амжилт таныг дагах болно. Та ажилдаа гаргасан бүтээл тань таны нэр хүндийг өсгөх болно. Ингэснээр таны цалин нэмэгдэж, тушаал ахина. Гадны түншүүдтэй байгуулах гэрээ хэлэлцээр, хөрөнгө оруулалт, дэмжлэг тусалцаа таны талд байх болно. Зарим нь эртнээс мөрөөдөж байсан зүйлээ эхлүүлж чадна. Амжилттай яваа нэр алдарт хүрсэн хэн нэгнээс зөвлөгөө аваарай.



Матар /XII.22-I.19/

Та тархиа зөв удирдаж, бүх зүйлийг сийргээр, олон талаас нь харж бодож боловсруулж чадах юм бол танд тулгарсан сорилтыг амжилттай давж чадна. Энэ нь эргээд танд зорьсон зорилтдоо хүрэх, төлөвлөгөөгөө биелүүлэх таатай боломжийг нээж өгөх юм. Гэр бүл болон ойрын хүмүүстэй хийсэн бага зэргийн маргаанаа өнөөдөр засан залруулж таатай уур амьсгалыг бүрдүүлж чадах юм.



Үхэр /IV.20-V.20/

Сөрөг хандлага давамгайлсан өдөр. Та сэтгэлийн хөдлөлөө дарж чаддаггүй, бүгдийн нүдэнд баярлаж гуниглах чинь ил байдаг. Энэ үйлдлээсээ болж бусдын анхааралд өртөж атаархагчдын олз болно. Өөрийгөө баталж нотлох гэж хайран хүчээ барах хэрэггүй. Аяндаа байдал намжина. Хүүхдүүд хичээл сургууль дээр ямар нэгэн асуудал үүсгэнэ. Тэднийг ойлгож, зөв өнцгөөс нь хараад үзээрэй.



Арслан /VII.23-VIII.22/

Хэт ачаалалтай өдөр болно. Өөрийн бодож буй, төлөвлөж буй зүйлээ ганцаараа бодоод байлгүй бусадтай хуваалц. Санал сэтгэгдлийг нь сонсож байж дараагийн үр дүнд хүрэх болно. Тархиа ядраахгүй сэргэлэн аливаад түүртэхгүй байх нь таны эрүүл мэндэд тустай. Найз нөхөдтэйгөө оройг хамтдаа өнгөрүүлээрэй.



Хилэнц /X.23-XI.22/

Ажлын эрч хүч буурсан, сэтгэл гонсойлгосон өдөр. Бүх хүн, бүх зүйл танаас холдож байгаа мэт сэтгэгдэл төрүүлнэ. Энэ нь таны өөрийн дотоодтой холбоотой болохоор хэн нэгэн өөрийгөө илүү сайн ойлгож, дэмждэг хүнтэйгээ сэтгэлээсээ ярилцаж чадвал таагүй нөхцөл байдлаас ангижирч чадна. Ганц бие хүмүүс хайр дурлалтайгаа удахгүй учирна. Та уян дөлгөөн, романтик байхыг туйлын ихээр хүснэ.



Хумх /I.20-II.18/

Та өрсөлдөгчдөө өөрийнхөө сул талыг мэдрүүлснээр өнөөдрийн бүхий л төлөвлөгөөт ажлаа баллаж орхино. Хэн овсгоотой нь амжилтад хүрдэг хойно та өнөөдөр нэг алхам хоцорсон гэдгээ мэдэрнэ. Та сэтгэлийн тэнхээ, урам зоригоо сэргээж найзтайгаа үдшийг өнгөрөө, ярилц, бүх зүйл аяндаа хэвэндээ орно. Тууштай, эрс шийдэмгий зан тань таныг таагүй байдлаас зайлуулж чадна.



Хамтатгах /V.21-VI.21/

Та бүхний хийж хэрэгжүүлж байгаа ажил хэрэг амжилт дагуулахаас гадна нэмээд шинэ захиалгын санал хүлээж авна. Урам зоригийг ажил, хамт олноосоо хүртэх болно. Та нэр хүнд, албан тушаал ахих гэж хүч хаях хэрэггүй өөрийн тань ур чадвар, ажилдаа хандах хандлага чинь аль хэдийн дээшлэх замыг тань заагаад өгчихсөн.



Охин /VIII.23-IX.22/

Ажил хэрэг саадгүй, гэрээ хэлэлцээр амжилттай байж ямар ч хэлэлцүүлэгт та бусдыг гайхшруулж чадна. Гаргасан өчүүхэн амжилтдаа дэвж биеэ тоохгүй байхыг сануулж байна. Амьдралын эрч хүч буурч, урам хугарна. Хэрэв та нөхцөл байдлыг үнэн зөвөөр хурдан шуурхай үнэлж мөн биеэ авч явах байдлаа нөхцөл байдалд тааруулан тохируулж чадвал аливаа үүсэх таагүй байдлаас амархан гарч чадна.



Нум /XI.22-XII.21/

Аливаа харилцаа танд аз жаргал мэдрүүлнэ. Дуртай ажлаасаа таашаал авч, амьдралыг үргэлж гэрэл гэгээлгээр харж чаддаг таны төрөлхийн зан таныг олон сайхан хүмүүсээр хүрээлүүлэхэд ихээхэн нөлөөлдөг. Шинэ санаагаа хэрэгжүүлэх гэж мэрийх болно. Таны хичээл зүтгэл талаар болохгүй. Санхүүгийн байдал тань эрс нэмэгдэнэ.




Загас /II.19-III.20/

Ахмад настнууд, аав ээждээ санаа зовж, тэднийг яаж баярлуулах, явал сэтгэл санааг нь дэмжиж чадах бол гэсэн хүсэл бодлоор өнөөдрийн ихэнх цагийг зарцуулна. Та тэдэнд энэ өдрийг жаргалтай болгож өгч чадна. Шинээр тавьсан саналд та хөнгөн хуумгай хандаж хэрхэвч болохгүй. Үүнд дээд зэргийн анхааралтай, бодолтой хандаарай.

ДОРНЫН ЗУРХАЙ

Бизнес эхлэхэд сайн



Наран ургах, шингэх: 07:49-18:22 цаг
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй
Суудал: Мод

Аргын тооллын хоёрдугаар сарын 21, Сугар гараг. Билгийн тооллын 28, Яруу эгшигт одтой, хөх морь өдөр.

Өдрийн наран 07:49 цагт мандаж, 18:22 цагт жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, зэрэг дэвших, гарагийг тахиж, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1			2	3	4		5	6		
		7					8			
9		10		11		12	13		14	
				15						
	16									
17										18
19		20		21		22		23		
24				25						26

БОСООГООР:

- 1. Ойн жижиг мэрэгч амьтан
- 3. М.Шолоховын алдарт романы мөрөн гол
- 4. Хол
- 6. Нэгэн төрлийн ирвэс
- 7. Үндэс
- 8. Монголд хамгийн олон жил үүрэг гүйцэтгэсэн Оросын нисэх онгоц
- 10. Хишиг, эерэг гэсэн утгатай үг
- 11. Бодын шагай
- 13. Өмнөд хөрш улсын хилийн хот
- 14. Уй, уйтгар
- 15. Дулаан
- 17. Түшиг
- 18. Мьянмар улсын хуучин нэр
- 20. Биеийн төлөөний нэр
- 21. Хурд хамтлагийн 25 жилийн ойд зориулсан тоглолтын нэр
- 22. Хамгийн өндөрлөг тив
- 23. Хөгжмийн нот

ХӨНДЛӨНГӨӨР:

- 1. Нарийн зөрөг зам
- 2. Эмэгтэй бөө
- 5. Католик шашны тэргүүн лам
- 9. ЗХУ-ын удирдагч М.Горбачеваас Берлиний ханыг нурааж хаалгаа нээхийг шаардаж, алдарт үгээ хэлсэн АНУ-ын Ерөнхийлөгч
- 12. Хэрэйдийн Тоорил ван хааны жетөөч хүү
- 16. Академи авардс 2018 кино наадмын шилдэг кино зохиол (М.Эрдэнэбат)-оор шалгарсан кино
- 19. Мал маллаж аж төрдөг хүмүүс
- 22. Тангараг
- 23. Гойд онцгой
- 25. Бүдүүн (басс) хоолой
- 26. Аяар

Өмнөх дугаарын хариу 02.20

Ж	И	Г	О	М	Е	Р	И	М
А	Ш		Ө		Ж		А	
Н		Э		Р	И		Н	
Ч	И	М	Э	Д	Д	О	Р	Ж
Х		Р		О		А		У
Ү	Х			Р		К		У
Ү	Ү	Х	У	Ж	А	А	А	Р

ЗГМ: СУДОКУ

			7	9	5		8	
3	8							
						7		2
	6				9			
	3				8			4
						2	1	9
		2	3	7				
4			1			6		
								3

Өмнөх дугаарын хариу

5	6	7	2	8	9	4	3	1
8	9	2	4	3	1	5	7	6
4	1	3	7	5	6	2	8	9
7	2	1	3	9	8	6	5	4
3	4	9	5	6	2	8	1	7
6	8	5	1	4	7	3	9	2
9	5	8	6	7	4	1	2	3
2	3	4	9	1	5	7	6	8
1	7	6	8	2	3	9	4	5

ЖИГНЭСЭН ТАХИАНЫ ГУЯ

Тахианы мах нарийн ширхэгтэй, өөх тос маш бага хэмжээгээр агуулдаг, уургийн агууламж өндөр учир бага насны хүүхэд болон өндөр настан, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэж буй хүмүүст хамгийн тохиромжтой. Мөн ханаагүй өөх тос болох линолын хүчил агуулдаг учир хорт хавдраас урьдчилан сэргийлдэг. Ингээд Caelum Saferante рестораны ахлах тогооч Ч.Гэрэлмаагийн жорыг хуваалцаж байна.

ОРЦ:

- Тахианы цул мах-2 ш
- Ногоон чинжүү-2 ш
- Лууван-100 гр
- Ургамлын тос-2 а/х
- Лаазалсан улаан лооль-400 гр
- Ногоон чили- 40 гр
- Сонгино-50 гр
- Тахианы шөл- 200 гр

ШИМ ТЭЖЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ:

- **Нийт калори:** 450 ккал
- **Уураг:** 210 гр
- **Нүүрсус:** 190 гр
- **Өөх тос:** 60 гр

ХЭРХЭН ХИЙХ ВЭ:

Чинжүүгээ том дөрвөлжин, сонгино болон луувангаа нимгэн хавтгай хэрчиж, давс, перцээр амтлаад бага зэрэг хуурна. Үүн дээрээ лаазалсан улаан лоолио хийгээд зөөлөн гал дээр буцалгаарай. Шанзаа буцалж байх хооронд тахианы махаа төмөр саванд хийгээд, ургамлын тосондоо хоёр талаар нь хөнгөн шарж, хайрс тогтооно. Тахиагаа шанз болон ногоон чилигээр амталж, шөлөө хийгээд зөөлөн гал дээр 20 минут жигнэнэ.